

Элч Нарын Тунхаг

3-р хичээл

Есүс Христ

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c)(3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Элч нарын тунхаг

3-р хичээл

Есүс Христ

Гарчиг

УДИРТГАЛ	1
БУРХАН ЧАНАР	2
Бурханы Хүү.....	2
Эзэн	5
ХҮМҮҮН ЧАНАР	6
Хүмүүн туршлага.....	7
Угсаа гарал.....	7
Бие махбод.....	8
Сүнс.....	9
Амилал.....	10
Албан үүрэг	11
Хуучин гэрээний үндэслэл.....	11
Есүс доторх биелэл.....	13
Мөн чанар.....	14
ҮЙЛ ХЭРЭГ	18
Дорд болсон нь.....	18
Биежилт.....	19
Зовлон шаналал.....	21
Өргөмжлөгдсөн нь.....	24
Амилал.....	25
Тэнгэр өөд одсон нь.....	26
Хаан сэнтийд заларсан нь	27
Шүүлт.....	28
ДҮГНЭЛТ	29
ХАМТРАГЧИД	30
ҮГСИЙН ТАЙЛБАР	32

Элч нарын тунхаг

3-р хичээл

Есүс Христ

УДИРТГАЛ

Сүүлийн хоёр мянган жилийн турш олон тэрбум хүн Назарын Есүсийн Сайнмэдээг тунхаглаж, итгэн дагаж, хүндлэн магтсаар ирсэн. Түүхэнд өөр хэн ч ийнхүү бүх нийтэд хүндлэгдэн, нийгэмд ийм их нөлөө үзүүлж байгаагүй юм. Уран зураачид, хөгжимчид, зохиолчид бүгд л Түүнийг уран бүтээлийнхээ сэдэв болгосон байдаг. Түүний сургаал дээр улс үндэстнүүд хийгээд соёл иргэншлүүд бий болсон. Дэлхийн олон орны цаг тоолол Түүний төрсөн цагаас эхэлдэг.

Гэвч Есүс хэдий алдартай ч одоог хүртэл судалгаа шинжилгээний гол сэдэв хэвээр л байна. Бүх салбарын судлаачид Түүнийг судалж, үл итгэгчид Түүнийг гутаах гэж оролддог. Харин дагалдагчид нь Түүнийг байж болох бүхий л замаар судалсаар байна.

Үнэндээ Есүсийн тухай таньж мэдэх нь хүн бүрийн хувьд чухал юм. Учир нь нэг л өдөр бид бүгд "Есүс Христ гэж хэн бэ?" гэсэн асуултад хариулах хэрэгтэй болно. Христитгэгчдийн хувьд олон зууны туршид Элч нарын тунхгийг уншиж, тунхагласаар ирсэн тул хариулт нь бүгд адил байх нь лавтай.

Энэ бол Элч нарын тунхаг цуврал хичээлийн маань гурав дахь хичээл бөгөөд "Есүс Христ" гэдэг нэртэй байна. Уг хичээлээрээ бид Гурвалын хоёр дахь бодгаль болох Бурханы Хүү, Есүс Христэд итгэх итгэлийг баталдаг итгэлийн үндсэн тунхаглалуудад анхаарлаа хандуулах болно. Үүнд дараах тунхаглалууд багтана:

**Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариас мэндэлсэн,
Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад
Үхэгсдийн орон руу яваад,
Гурав дахь өдрөө үхлээс дахин амилсан,
Тэгээд мөнхийн улс руу одож,
Төгс хүчит Бурхан Эцэгийнхээ
Баруун мутарт заларсан,
Тэндээс үхсэн, амьд
Бүх хүнийг шүүхээр ирэх
Түүний цорын ганц Хүү
Бидний Эзэн Есүс Христэд би итгэдэг.**

Тунхаг дахь Есүсийн тухай хэлсэн бүхнийг олон янзаар хураангуйлж болох ч бид теологийн түүхэнд үргэлж анхаарлын төвд байсаар ирсэн гурван гол сэдвийг судлах болно. Нэгдүгээрт, бид Есүс Христийн Бурхан чанарын тухай ярилцахдаа Түүний бурханлаг мөн чанар болон Гурвалын бусад бодгалиудтай харилцах харилцааных нь тухай авч үзэх болно. Хоёрдугаарт, бид Түүний хүмүүн чанарыг судалж, Түүний бурханлаг болон хүмүүн мөн чанарын хоорондын харилцааг авч үзнэ. Гуравдугаарт, бид Түүний үйлсийн тухай ярилцана. Ингэхдээ Түүний дэлхий дээрх үйлчлэл төдийгүй үүний дараах ажил үйлсийнх

нь тухай ч ярилцах болно. Ингээд одоо бүгдээрээ *Элч нарын тунхагт* Есүс Христийн Бурхан чанарын тухай юу гэж заасныг авч үзье.

БУРХАН ЧАНАР

Бид Христийн Бурхан чанар буюу Тэрээр бүрэн дүүрэн Бурхан мөн гэсэн Христийн бурханлаг мөн чанарын тухай ярихдаа Христ хэн бэ гэдэг Шинэ Гэрээний үндсэн тунхаглалын тухай ярьж байна гэсэн үг юм. Уг тунхаглалд Есүсийг бүрэн дүүрэн Бурхан, мөн бүрэн дүүрэн хүн гэсэн байдаг. Энэ хоёр үнэний аль нэгээс нь татгалзах үед бидэнд Есүс гэж үгүй болдог. Тиймээс бид Түүний бурханлаг мөн чанарыг Библид юу гэж зааснаар л тайлбарлах учиртай. Библид Түүнийг амьд Бурханы Хүү гэдэг. Энэ бол анхны чуулганы үндсэн гол сургаал юм. Жишээ нь, Колоссай номд элч Паул бичихдээ Есүс бол бүхнээс дээгүүр агуу хүч чадалтай гэсэн байдаг. Түүн дотор бүх зүйлс бүтээгдсэн бөгөөд бүх хүч чадал Түүний өлмийн дор байдаг гэжээ. Тэгвэл зөвхөн Бурханы тухай л ингэж хэлэх боломжтой байдаг. Энэ үнэнийг л аваад хаячихвал Сайнмэдээ гэж үгүй, Есүс ч гэж үгүй, Христитгэл ч гэж үгүй болно.

-Др. Р. Алберт Мохлер, Жр.

Элч нарын тунхагт Есүсийн Бурхан чанарын тухай өгүүлэхдээ:

Түүний цорын ганц Хүү, бидний Эзэн Есүс Христэд би итгэдэг гэжээ.

Христитгэгчид Есүсийн бурхан чанарыг тодорхойлохдоо "Христ", "Бурханы Хүү", "Эзэн" зэрэг үгсийг зориудаар хэрэглэж ирсэн.

Бид Элч нарын тунхаг дахь Христийн Бурхан чанарыг илэрхийлдэг хоёр л хэллэгийг авч үзэхээр зорилоо. Бид нэг талаас Есүс бол Бурханы Хүү гэдгийг харах бол нөгөө талаас Есүс бол Эзэн гэдэг нь ямар утгатай болохыг судлах болно. Ингээд Библид Есүсийг "Бурханы Хүү" гэсэн нь ямар утгатай болохыг эхлээд харцгаая.

Бурханы хүү

Юуны өмнө "Бурханы Хүү" гэдэг үгийг Библид ихэнхдээ бурхан биш нэгний тухай ярихдаа ашигласан байдгийг хэлэх нь зүйтэй. Жишээ нь, Иов 1:6, 2:1 зэрэг эшлэлүүдэд тэнгэр элч нарыг Бурханы хөвгүүд гэж нэрлэсэн байдаг. Гэвч орчин цагийн Библийн зарим хувилбаруудад эдгээр эшлэлүүдийг Бурханы хөвгүүд бус "тэнгэрэлч нар" гэж орчуулсан нь бий. Гэвч үнэндээ Иов номд Еврей хэлээр "бэнаи хаэлохим" буюу шууд утгаараа "Бурханы хөвгүүд" гэсэн. Бид өөр бусад эшлэлүүдээс ч үүнтэй ижил хэллэгүүдийг олж хардаг.

Мөн Гэтлэл 4:22, Хосеа 11:1 зэрэг эшлэлүүдэд Израиль үндэстнийг Бурханы хүү гэж нэрлэсэн байдаг. Израилийн хаадыг мөн л Бурханы хөвгүүд хэмээн 2Самуел 7:14, Дуулал 2:7 зэрэг эшлэлүүдэд тодорхойлсон. Анхны хүн Адамыг ч Бурханы хүү гэж Лук 3:38-д өгүүлжээ.

Библид олон удаа Бурханд итгэмжит итгэгчдийг Түүний хөвгүүд хэмээсэн байдгийг бүх итгэгчид мэдэх биз ээ. Бид үүнийг Матай 5:9, 45, Лук 20:36, Ром 8:14, 19 зэрэг эшлэлүүдээс харж болно. Паул Галат 3:26 дээр энэ талаар өгүүлсэн байдаг. Энд:

Тийнхүү та нар бүгдээрээ Христ Есүст итгэх итгэлээр Бурханы хөвгүүд болсон ажээ (Галат 3:26).

Тэгвэл "Бурханы Хүү" гэдэг нэр нь Есүсийн бурханлаг мөн чанарыг илэрхийлсэн утгагүй юм бол яагаад чуулган энэ үгийг ихэд чухалчилдаг юм бол?

Бид Шинэ Гэрээнд Есүсийн тухай хэрхэн өгүүлдгийг харвал Тэрээр Бурханы хосгүй онцгой Хүү гэдэг нь тодорхой болдог.

Үнэндээ Есүс бол Бурханы онцгой Хүү гэдэг нь Шинэ Гэрээн дэх хамгийн чухал зүйлсийн нэг юм. Тэрээр Бурханы мөн чанар бүрийг хуваалцдаг. Өөрөөр хэлбэл, Есүс бол жинхэнэ Бурханы жинхэнэ Бурхан. Бид мөн чанараараа бус харилцаа ба үрчлэлтээрээ Бурханы хүүхдүүд болсон юм. Есүс бол Бурханы мөнхийн Хүү. Тэр үргэлж л Бурханы Хүү байсаар ирсэн.

-Др. Томас Р. Шрейнер

Есүсийн энэхүү онцгой Хүүгийн харилцааг Иоханы Сайнмэдээнээс тодорхой харж болдог. Жишээ нь, Есүс бол Бурханы мөнхийн Үг буюу Өөрөө Бурхан байсан бөгөөд Эцэгээс цор ганц Төрөгч хэмээн Иохан 1:1-18 дээр өгүүлсэн нь буй. Бид түүнчлэн Бурхан Эцэгийн Хүү Тэрээр дээрээс ирсэн бөгөөд энэ ертөнцийнх биш гэдгийг Иохан 8:18-23-р эшлэлээс харж болно. Мөн Иохан 10:30 дээр Есүс Өөрийгөө Эцэгтэйгээ нэг гэдгийг онцолсон байдаг.

Гэхдээ Иохан 5:18-р эшлэлд Иохан энэ талаар хамгийн тодорхой тайлбарласан байдаг. Түүнийг юу гэж бичсэнийг сонсоцгооё:

[Есүс] мөн Бурханыг Эцэгээ хэмээн Өөрийгөө Бурхантай адилтгасан юм (Иохан 5:18).

Энэ хэсэгт Есүс Өөрийгөө Бурханы Хүү гэж хэлэхдээ Бурхан Эцэгтэйгээ Өөрийгөө адилтгасан болохыг тодорхой өгүүлжээ. Тийм ч учраас Христитгэгчид Есүс бол Бурханы Хүү хэмээн Библи хэлэх үед Түүнийг онцгой бас бурханлаг Нэгэн мөн гэж зөв зүйтэй ойлгодог.

Есүс бол бурханлаг Хүү болохыг Шинэ Гэрээний бусад олон эшлэлд дурдсан байдаг. Есүс хүн болохоосоо буюу биежилтээсээ ч өмнө Бурханы бурханлаг Хүү байсан хэмээн Паул Ром 1:3-4, 8:3 дээр заасан. Есүс Бурханы Хүү учраас дэлхий ертөнцийг бүтээсэн ба Эцэгийн оршихуйн илэрхийлэл байсныг Еврей 1:1-3-р эшлэлээс харж болно. Эдгээр болон бусад олон газарт Есүсийг Бурханы Хүү гэж тодорхойлсон нь Түүний мөнхийн, бурханлаг мөн чанарыг харуулдаг.

Есүсийг Бурханы мөнхийн, бурханлаг Хүү хэмээн онцолсон нь Гурвалын онолд тусгагдсан байдаг. Энд:

Бурхан бол гурван бодгальтай ч мөн чанарын хувьд нэг юм.

Есүс бол Хүү Бурхан буюу Гурвалын гурван бодгалийн нэг гэж Шинэ Гэрээнд заадаг. Тэгвэл Тэрээр Эцэг ба Ариун Сүнстэй ямар харилцаатай вэ?

Гурвалын талаарх онтологийн үзэл нь Бурханы оршин тогтнол ба оршихуйд анхаарлаа хандуулдаг гэж бид өмнөх хичээлээр үзсэн. Христ Бурханы Хүү учраас Эцэг болон Ариун Сүнстэй адил хүч чадал, алдар суутай. Хүүг оролцуулаад Бурханы гурван бодгалиуд нь цаглашгүй, мөнх бас хувиршгүй юм. Бодгаль бүр мэргэн ухаан, хүч чадал, ариун байдал, шударга ёс, сайн сайхан болон чин үнэн зэрэг үндсэн бурханлаг чанаруудтай.

Харин Гурвалын талаарх экономик үзэл нь Бурханы бодгалиуд хоорондоо хэрхэн харилцдаг болохыг тайлбарладаг. Энэ үзлийн дагуу бол бодгаль бүр өөр өөр хариуцлага, гүйцэтгэх үүрэг ба эрх мэдлийн түвшинтэй байна. Жишээ нь, Христ үргэлж Эцэгийн Хүү байж, Эцэгийн эрх мэдэлд захирагддаг гэж үздэг. Есүс Эцэгтээ захирагддаг тухайгаа Иохан 6:38-р эшлэлд өгүүлсэн байдаг. Энд:

Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг үйлдэхээр тэнгэрээс бууж ирсэн юм (Иохан 6:38).

Мөн Тэрээр Иохан 8:28-29-р эшлэлд үүнтэй адил зүйлийг тунхагласан. Энэ нь:

Тиймээс Есүс [тэдэнд] "Та нар Хүний Хүүг өргөгдөх цагт л Би байгаа гэдгийг мөн Би юуг ч Өөрөөсөө хийдэггүй, харин Эцэгийн Надад зааснаар эдгээрийг ярьдаг гэдгийг мэдэх болно. Намайг Илгээгч нь Надтай байгаа. Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг учир Тэр Намайг ганцааранг минь орхисонгүй" гэжээ (Иохан 8:28-29).

Хүү үргэлж Эцгийн эрх мэдэлд захирагдаж байсныг бид Шинэ Гэрээнээс хардаг. Хүү болон Эцэг хоёр үргэлж санал нийлдэг тул тэдний дунд зөрчил гэж үгүй. Харин Эцэгт илүү дээгүүр эрх мэдэл байдаг.

Үүнчлэн Гурвалын экономик үзлийн хүрээнд бол Хүү Ариун Сүнсний дээр эрх мэдэлтэй байна. Жишээ нь, Иохан 15:26 дээрх Есүсийн үгсийн сонсоцгооё. Энэ нь:

Би Эцэгээсээ та нарт Туслагчийг илгээнэ. Тэр бол Эцэгээс гарах үнэний Сүнс мөн. Тэр ирэхдээ Намайг гэрчилнэ (Иохан 15:26).

Мөн Ром 8:9, Петр 1:11 зэрэг эшлэлүүдэд Ариун Сүнсийг "Христийн Сүнс" гэж нэрлэсэн байдаг. Энэ нь Христ Сүнсийг илгээсэн гэдгийг тодорхой харуулдаг юм.

Эдгээр харилцаануудыг нэгтгэн дүгнэвэл Хүүг Гурвалын хоёрдох бодгаль гэж тодорхойлж болно. Гурвалын онтологийн хувьд тэрээр хоёрдох бодгаль юм. Учир нь Тэрээр эхний бодгаль буюу Эцэгээс ирж, гуравдах бодгаль буюу Ариун Сүнсийг үлээн өгдөг. Мөн Гурвалын экономик үзлийн хүрээнд Тэрээр эрх мэдлийн хувьд яг дунд нь байдаг тул хоёрдох бодгаль болдог. Тэрээр Эцэгт захирагддаг ч Ариун Сүнсний дээгүүр эрх мэдэлтэй юм.

Анхны чуулганы үед Есүс Христ бол бүрэн дүүрэн Бурхан юм гэдгийг хүлээн зөвшөөрч итгэх нь Христитгэлийн маш чухал хэсэг байсан. Элч нарын тунхгийг хүлээн зөвшөөрч, баптисм хүртэж буй хүмүүсээс Гурвалын дотоод үйл ажиллагааны талаарх

теологийн бүх нарийн ширийн зүйлсийг батлахыг шаарддаггүй байв. Гэвч тэд Христийн бурханлаг чанарыг эргэлзэлгүйгээр хүлээн зөвшөөрөх ёстой байв. Өнөөдөр ч мөн Есүсийг үнэн бөгөөд бүрэн дүүрэн Бурхан гэдгийг хүлээн зөвшөөрөх нь библийн дагуух Христитгэлийн шалгуур мөн.

Ингээд бүгдээрээ "Бурханы Хүү" гэсэн үгийн ач холбогдлыг авч үзлээ. Одоо тэгвэл "Эзэн" гэдэг үг Есүсийн Бурхан чанарыг хэрхэн тодорхойлдог болохыг үзэхэд бэлэн боллоо.

Эзэн

Шинэ Гэрээнд Есүсийг Эзэн гэж дууддаг ба энэ нь Грек хэлний куриос гэдэг үг юм. Куриос нь захирагч эсвэл эзэнтэн гэсэн утгатай түгээмэл хэрэглэгддэг үг байсан. Мөн энэ үгийг Англи хэлний ноён, ноёнтон гэсэн үгтэй адил хүндэтгэлийн зорилгоор ашигладаг байжээ. Тиймээс энэхүү куриос гэдэг үгийг Матай 10:24, Лук 12:36-47, Ефес 6:5-9 болон бусад олон эшлэлд энгийн хүний тухай өгүүлэхдээ ашигласан нь бий.

Үүний зэрэгцээ Матай 11:25, Лук 1:16, Үйлс 2:39 гэх мэт Шинэ Гэрээний олон хэсэгт куриос хэмээх энэ үгийг Бурханыг нэрлэхдээ ашигласан байдаг. Тэгвэл өргөн утгаар ашиглагддаг энэ үгийг яагаад Шинэ Гэрээнд Есүсийн Бурхан чанарыг илэрхийлдэг гэж үздэг юм бол? Бид яагаад энэ үг зүгээр л Түүний дэлхий дээрх эрх мэдэл ба алдрыг илэрхийлдэг гэж бодож болохгүй гэж?

Христитгэлд куриос гэдэг үгийг ашиглах гол түлхүүр нь Хуучин Гэрээ юм. Хуучин Гэрээний бичвэрүүд Еврей хэл дээр бичигдсэн. Гэвч эдгээр нь Христийг мэндлэхээс хэдэн зууны өмнө Еврей хэлнээс Грек хэл уруу орчуулагдсан байдаг. Энэхүү орчуулгыг Септуагинт гэж нэрлэдэг. Еврей судлаачид Хуучин Гэрээг Грек хэл рүү орчуулахдаа Бурханы ард түмэндээ Өөрийгөө илчилсэн ариун дагшин нэр болох ЯВЭ гэдгийг куриос хэмээх грек үгээр илэрхийлсэн ба нийт 6700 удаа гардаг. Энэ нь Шинэ Гэрээнд Есүсийг куриос гэж нэрлэснийг ойлгоход туйлын чухал үүрэгтэй. Куриос гэдэг үг нь дангаараа Есүсийн Бурхан чанарыг шууд илэрхийлдэггүй боловч Хуучин Гэрээн дэх хэрэглээнд нь үндэслэн харвал энэхүү үг нь бичвэрийн олон хэсэгт Есүсийн Бурхан чанарыг илэрхийлсэн болохыг ойлгох болно.

-Др. Кэйт Жонсон

Шинэ Гэрээний хамгийн гайхалтай эшлэлүүдийн нэг бол "Ингэснээр Есүсийн нэрд бүгд өвдөг сөгдөж, хэл бүхэн Есүс Христийг Эзэн хэмээн өчиж, Эцэг Бурханд алдрыг өргөхийн төлөө ажээ" гэсэн эшлэл юм [Филиппой 2]. Үнэндээ Паул энд ЯВЭ бол Эзэн мөн гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрнө гэсэн Исаиа номын магтуу дуунаас эш татсан байдаг. Тэрээр зүгээр л Есүс Христ бол Эзэн гэхийн оронд Хуучин Гэрээнээс зориудаар эш татжээ. Шинэ Гэрээнд энэ үгийг ашиглахдаа Есүс Христ бол зүгээр нэг эзэн биш харин Израйлийн Бурхан Эзэн гэсэн утгаар бичсэн нь тодорхой байна.

-Др. Петр Волкер

Энэ тухай Паул Ром 10:9, 13 дээр өгүүлсэн байдаг. Энд:

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдана... Учир нь “Эзэний нэрийг дуудсан бүхэн аврагдана.” гэжээ (Ром 10:9, 13).

Паул Есүсийн нэрийг дуудсан хүн бүр аврагдана гэдгийг батлахын тулд 13-р эшлэлд Иоел 2:32-г эш татсан байдаг. Гэвч Еврей Хуучин Гэрээний Иоел номын энэ эшлэлд Эзэн гэдэг нь ЯВЭ буюу Бурханы Өөрийнх нь нэр байдаг. Энгийнээр хэлбэл Паул Есүсийг Эзэн гэсэн нь Есүс бол ЯВЭ, Хуучин Гэрээний Эзэн ба Бурхан юм хэмээжээ.

Матай 3, Марк 1, Лук 3, Иохан 1-р бүлэг зэрэг Шинэ Гэрээний олон хэсэгт Есүсийг Хуучин Гэрээний Бурхантай адилтгасан байдаг. Өөрөөр хэлбэл Исаиа 40-р бүлэг дээрх Эзэн бол Есүс мөн бөгөөд Түүний замыг Иохан Баптист бэлтгэсэн юм. Бид Еврей 1:10 дээрх Эзэн Есүс бол Дуулал 102:24-25 дээрх дэлхий ертөнцийг бүтээсэн Бурхан мөн гэсэн санааг харж болно. Энэ мэт жагсаалтууд ар араасаа хөвөрнө.

Мэдээж Шинэ Гэрээнд Есүсийг Эзэн гэж дуудсан хүн бүр Түүний Бурхан чанарыг тэр бүр анзаарч, ухаараагүй байдаг. Заримдаа зүгээр л хүн ёсны хүндлэлийн үүднээс Есүсийг Эзэн гэж дуудсан байдаг. Харин чуулган Элч нарын тунхгийн дагуу Есүс бол Эзэн хэмээн хүлээн зөвшөөрснөөр Есүс Христ бол Бурхан бөгөөд Эцэг болон Ариун Сүнстэй адил Бурхан чанартай, Гурвалын бүрэн дүүрэн гишүүн гэдгийг батлан тунхагладаг.

Христийн Бурхан чанар нь Христитгэлийн амьдралд бүхий л талаар нөлөөлдөг. Тухайлбал, энэ нь бид залбирал ба магтаалдаа Есүсийг Бурхан гэдгийг хүлээн зөвшөөрч, хүндлэн мөргөх ёстой гэсэн үг. Энэ нь бид Эцэг болон Ариун Сүнсэнд залбирдагтай адил Есүст залбирах ёстой гэсэн үг юм. Мөн энэ нь Бурхан Өөрөө биднийг нүглээс гэтэлгэсэн гэдгийг мэдэж, авралынхаа баталгаанд бүрэн итгэлтэй байж чадна гэсэн үг болдог. Есүс бол Бурхан гэдэгт итгэх итгэлээс Христитгэлийн амьдралд маш олон бодит нөлөө, үр дүн гардаг билээ.

Ингээд бид Есүсийн Бурхан чанарын тухай ойлголттой боллоо. Тиймээс одоо бүгдээрээ Элч нарын тунхаг дахь Түүний хүмүүн чанарын тухай үзэцгээе.

ХҮМҮҮН ЧАНАР

Сүүлийн хэдэн зуунд олон теологчид Есүсийг хүн байсан гэдгийг шууд хүлээн зөвшөөрдөг ч Түүний Бурхан чанарт эргэлзсээр ирсэн. Харин чуулганы анхны зуунуудад хүмүүс Есүсийн хүмүүн чанарт эргэлзэх нь нийтлэг байв. Тухайн цаг үеийн гүн ухааны үзлийн нөлөөгөөр бурхан хүний дүрд хувирч болно гэдэгт итгэх нь хүмүүст амархан байсан. Гэвч бурхан өөрөө жинхэнэ хүн болно гэдгийг хүлээн зөвшөөрөхөд тэдэнд маш хэцүү байв. Хүн гэдэг бол бие махбод, сэтгэл хөдлөл бүхий оршихуй юм. Бурхан Өөрийн алдар ба сүр жавхлангаа орхин, өчүүхэн сул дорой бүтээл болох хүний дүрийг авна гэдэг тэдний санаанд багтамгүй зүйл байжээ. Харамсалтай нь орчин цагийн Христитгэгчид ч мөн Хүү Бурхан газар дэлхий дээр ирж, сул дорой, хязгаарлагдмал хүмүүн чанарыг олж төрнө гэдэгт эргэлздэг.

Бид Есүсийг бүрэн дүүрэн хүн байсан гэдгийг тайлбарлахын тулд Түүний хүмүүн чанарын гурван үндсэн онцлогийн тухай ярилцах болно. Нэгдүгээрт, бид Түүний хүмүүн туршлагын талаар авч хэлэлцэнэ. Хоёрдугаарт, бид Түүний хүмүүн байр суурь буюу үүргийн тухай ярилцана. Гуравдугаарт, бид Түүний хүмүүн ба Бурханлаг мөн чанарын

хоорондын харилцааг судлах болно. Ингээд одоо *Элч нарын тунхагт* бичигдсэн Түүний хүмүүн туршлагыг эхлээд үзэцгээе.

Хүмүүн туршлага

Зөвхөн хүмүүний л туулдаг олон зүйлсийг Есүс амьдралаараа туулсан нь Түүнийг жинхэнэ хүн байсан гэдгийг баталдаг. Тунхагт бичигдсэн дараах баталгааг хамтдаа харцгаая.

**[Есүс] Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариас мэндэлсэн,
Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад
Үхэгсдийн орон руу яваад,
Гурав дахь өдрөө үхлээс дахин амилсан.**

Есүсийн туулсан эдгээр зүйлс Түүний хүмүүн чанарын дор хаяж дөрвөн талыг батлан харуулдаг. Эдгээр нь Түүний угсаа гарал, бие махбод, сүнс сэтгэл ба амилалтынх нь тухай байна. Ингээд эхлээд Тэрээр хэрхэн олдож, мэндэлсэн талаарх Түүний угсаа гарлын тухай үзэцгээе.

Угсаа гарал

Элч нарын тунхагт Есүсийн угсаа гарлын тухай дараах зүйлсийг өгүүлдэг. Энд:

**[Тэр] Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариас мэндэлсэн гэжээ.**

Мэдээж Есүс хэрхэн олдож, мэндэлсэн нь ер бусын гайхамшгаар дүүрэн байсан. Юуны өмнө Тэрээр жирийн хүнээс биш Ариун Сүнсээр олдсон. Ингэхдээ Тэрээр эхийнх нь онгон байдал хөндөгдөхгүй байдлаар олдсон. Бид энэ хичээлийн дараа энэхүү нарийн ширийн зүйлсийн талаар илүү дэлгэрэнгүй ярих болно. Харин одоо бүгдээрээ хүмүүний амьдралын салшгүй хэсэг болох Тэрээр хэрхэн эхийн хэвлийд олдож, мэндэлсэн талаарх үндсэн ойлголтод анхаарлаа хандуулцгаая.

Элч нарын тунхагт Есүсийг "олдож" гэж хэлсэн нь Адам, Ева хоёроос хойших бүх хүн төрөлхтний л адил Есүс эхийнхээ хэвлийд ураг болон бүрэлдсэн гэдэг санааг харуулахыг зорьсон юм. Бурхан Есүсийг Мариагийн хэвлийд хүн бүрийг хэлбэршүүлдэг шигээ бүрэлдүүлсэн тухай Матай 1:18, Лук 2:5-6, Галат 4:4, Еврей 10:25 зэрэг эшлэлүүдэд өгүүлдэг.

Лук 1:34-37 дээр Мариа хэрхэн хүүхэдтэй болох тухай Мариа болон тэнгэр элч Габриел хоёрын яриа гардаг.

Мариа тэнгэрэлчид "Би онгон атал энэ нь яаж бүтэх билээ?" гэв. Тэнгэрэлч "Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ...Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй" гэж хэлэв (Лук 1:34-37).

Ийм арга замаар хүүхэд олоход нь гайхамшиг байхаас өөр аргагүй гэдгийг Мариа ойлгож байсан. Үнэхээр ч түүнд тийнхүү гайхамшиг тохиолдсон юм.

Есүс ийнхүү гайхамшигтайгаар эхийн хэвлийд олдсон нь Түүнийг бүрэн дүүрэн Бурхан төдийгүй бүрэн дүүрэн хүн байсан гэдгийг ч баталдаг. Энэ нь Түүнийг бүрэн дүүрэн хүн биш байсан гэсэн утгыг агуулдаггүй. Түүний хэвлийд олдсон арга зам нь ер бусын байсан нь үнэн бөгөөд авралын түүхийн хамгийн агуу гайхамшиг ч байж мэдэх юм. Харин Есүс эхийн хэвлийд бүрэлдсэнээс хойших ургийн хөгжил, өсөж бойжих бүхий л явц энгийн хүнийхтэй л адил үргэлжилсэн. Тэрээр хүүхэд яаж төрдөг, яг л тэр үйл явцын дагуу эхийн хэвлийгээс мэндэлсэн. Тэрээр мөн хооллон, өсөж бойжихдоо эхээсээ бүрэн хамааралтай байсан ба ханиад хүрч нус нь гоожихоос авхуулаад хуурайлах гээд бүхий л талаар эгэл жирийн хүмүүний л туулдаг замаар замнасан. Тэрээр энгийн хүн биш ч, хүнээс ялгарах зүйлгүй байлаа.

-Др. Роберт Ж. Листер

Заримдаа хүмүүс Есүсийн эцэг нь хүн биш байсан тул Тэрээр бүрэн дүүрэн хүн байх боломжгүй хэмээн маргах нь бий. Гэтэл үнэндээ анхны хүмүүст ч мөн эцэг, эх байгаагүй шүү дээ. Эхлэл номын 2-р бүлэгт Адамыг газар шорооноос бүтээгээд, харин Еваг Адамын хавирганаас бүтээсэн гэж байдаг. Тэдний хэнд нь ч эцэг, эх байгаагүй. Тэдний хэн нь ч эхээс мэндлээгүй. Гэсэн ч тэд жинхэнэ, бүрэн дүүрэн хүн байсан шүү дээ. Яг л үүнтэй адил Есүс ер бусын арга замаар эхийн хэвлийд олдсон ч бүрэн дүүрэн хүн байсан юм.

Есүс эх Мариагийнхаа хэвлийд байгалийн жам ёсоор л өсөж бойжсон гэдгийг бид Бичвэрээс олж хардаг. Тэрээр гэнэт ид шидээр ч юм уу эсвэл тэнгэрээс буугаад ирчхээгүй. Харин ч эсрэгээрээ Матай 1, Лук 2-р бүлэгт Мариагийн жирэмслэлт эхэндээ хүмүүст анзаарагдахгүй байсан ч аажмаар нуухын аргагүй болсон гэдэг. Үүнээс болж Иосеф сүйт бүсгүйнхээ үнэнч байдалд эргэлздэг ч Бурхан түүний зүүдэнд үнэнийг хэлж өгсөн байдаг. Энэ бүхний эцэст Есүс нярай хүүхэд болон мэндэлсэн билээ.

Есүс бол бүрэн дүүрэн, жинхэнэ хүн юм. Эхийн хэвлийд ер бусын байдлаар бүрэлдсэн нь Христийн жинхэнэ хүмүүн чанарт огтхон ч нөлөөлөхгүй. Үнэндээ Есүс бидэнд хүн төрөлхтөнд анхнаасаа бүтээгдэхдээ байсан тэрхүү хүмүүн чанарыг харуулсан. Учир нь бид ямар ч гэм нүгэлгүй мөртөө бүрэн дүүрэн хүн байх боломжтой гэдгийг Христээс олж хардаг юм. Бид тэнгэрийн улсад яг л тийм байх болно.

-Др. К. Эрик Тоеннес

Ингээд бид Есүсийн угсаа гарлын тухай ярилцлаа. Одоо бүгдээрээ Түүний бие махбод нь Түүнийг бүрэн дүүрэн хүн байсныг хэрхэн баталдаг тухай авч үзье.

Бие махбод

Элч нарын тунхагт юу гэж заасныг дахин харцгаая. Энд:

[Есүс] Понти Пилатын дор зовж явсан, Цовдлогдон нас барж, оршуулагдсан гэжээ

Тунхагт хэлсэн эдгээр зүйлсийг Есүс зөвхөн жинхэнэ хүний бие махбодтой байсан тохиолдолд л туулах боломжтой юм.

Матай 27, Марк 15, Лук 23, Иохан 18-19-р бүлгүүдэд Есүс баригдан, цовдлогдсон тухай бичсэний дагуу тэр Понти Пилатын дор олон зовлонг эдэлсэн байдаг. Түүнийг ташуурдаж, өргөст титэм хүчээр өмсгөж, нулимж, доромжилж, толгой уруу нь дахин дахин цохиж, загалмайг нь үүрүүлэн цаазын газар уруу явуулсан

Есүсийн туулсан зовлон, цовдлол, үхэл, оршуулгаас бид Есүсийг бие махбодтой жинхэнэ хүн байсныг харж болно. Тэрээр зодуулсан, цус нь урссан, цэргүүдэд жанчуулж, харгислал дор тарчлан унасан, алагдсан, сүнс нь салан одоход чулуун булшинд оршуулагдсан тийм л бодит бие махбодтой хүмүүн байсан юм.

Бодит хүмүүн бие махбодтой байх нь туйлын чухал юм. Учир нь Бурханы шударга ёсны дагуу хүн төрөлхтний гэм нүглийг цагаатгахын тулд жинхэнэ хүмүүн бие махбодоор л тэнгэрлэг шүүлтийг амсан, зовлон эдлэх ёстой байв. Ром 7:4, Колоссай 1:21-22, Еврей 10:10 зэрэг эшлэлүүдэд энэ талаар онцлон бичсэн байдаг.

Еврей 2:14-17-р эшлэлийг жишээ болгон хамтдаа сонсоцгооё. Энд:

Тийнхүү хүүхдүүд нь мах цусны тасархай болов. Түүнчлэн Тэр Өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр...үхлээрээ ...хүмүүсийн нүглийн эвлэрүүллийг хийхийн тулд... гэжээ (Еврей 2:14-17)

Энэ эшлэлд Есүс бидний гэм нүглийн төлөөсийг төлөхийн тулд мах, цуснаас бүрдсэн хүний биетэй байх хэрэгтэй байсныг тодорхой хэлсэн байна.

Ингээд Есүсийн угсаа гарал болон бие махбодын тухай үзлээ. Одоо Есүсийн сүнс хүмүүн мөн чанарыг нь хэрхэн бүрэн гүйцэт болгосон тухай үзэцгээе.

Сүнс

Бичвэрт хүн гэдэг бол үхэшгүй мөнх сүнстэй, үхэж мөхдөг биеэс бүрдсэн амьд оршигч юм хэмээн олонтоо дурдсан байдаг. Библид хүний сүнсийг олон янзын үг хэллэгээр илэрхийлдэг ч ихэнхдээ "сүнс", "сэтгэл" гэсэн хоёр үгийг ашигласан байдаг. Еврей 4:12 болон 1 Тесалоник 5:23 дээр үндэслэн зарим уламжлалт үзэл нь "сүнс" ба "сэтгэл"-ийг хүний өөр өөр хэсгүүд гэж үздэг. Гэхдээ хүний дотоод буюу бие махбодын бус талыг бүхэлд нь илэрхийлэхдээ эдгээрийн аль нэг хэллэгийг ашигласан 200 орчим эшлэл Библид бий. Тиймээс "сүнс", "сэтгэл" гэдэг үгсийн аль аль нь хүн бол бие ба сүнс гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрддэг болохыг илэрхийлдэг гэж дүгнэх нь хамгийн зөв юм.

Лук 23:46 дээр Есүс үхэхийнхээ өмнө "сүнс", "сэтгэл" хоёрынхоо тухай ярьсан байдаг. Тэрээр энд:

Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая гэж чанга дуугаар хашхирав.. гэжээ (Лук 23:46).

Есүс загалмай дээр нас барахдаа Түүний бие булшинд тавигдах бол сүнс нь Бурхан Эцгийнхээ гарт байна гэжээ.

Бидний оршихуйн сүнслэг тал болсон сүнс маань ухамсрын маань эх сурвалж юм. Бидний бие махбод үхэхэд сүнс маань биеэсээ салан одох ба ухамсартай хэвээрээ байна. Мөн Элч нарын тунхаг нь Есүсийг нас барахад үүнтэй ижил зүйл тохиолдсон гэж тайлбарладаг. Тодруулбал энэ нь:

Тэрээр үхэгсдийн орон руу явсан... гэжээ

Есүсийг амьсгал хураасны дараа ухамсар бүхий сүнс нь биеэсээ салан одсон тухай тунхагт өгүүлдэг. Бие нь булшинд байхад, сүнс нь үхэгсдийн орон руу явсан гэжээ. Энэ хичээлээр бид үүний утга учрыг илүү дэлгэрэнгүй үзнэ. Гэхдээ одоохондоо Есүс үхэгсдийн орон руу явсан гэснээрээ Есүс жинхэнэ хүмүүн сүнстэй байсан гэдгийг Элч нарын тунхаг баталсан болохыг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Есүсийн хүмүүн чанарыг батлахын тулд Түүний угсаа гарал, бие махбод, сүнснийх нь тухай авч үзлээ. Түүнчлэн Элч нарын тунхагт Есүсийн сүнс биетэйгээ эргэн нэгдсэн тухай буюу үхлээс амилсан тухай мөн заасан байдаг.

Амилал

Амилал нь Есүсийг жинхэнэ хүн байсныг нь баталдаг. Учир нь энэ нь Түүний бодит хүмүүн бие махбод нь бодит хүмүүн сүнстэй нь дахин нэгдсэн Түүний бүрэн дүүрэн, алдаршуулагдсан хүмүүний оршихуйг нь дахин баталж өгдөг. Түүний биеийн амилал нь Түүний хүмүүн сүнс төгс болгогдсон хүмүүн биед нь орох үед болсон. Гийм ээ, Түүний үхлээс амилсан бие нь зарим талаараа өөр байсан. Яагаад гэвэл энэ нь алдаршуулагдсан бөгөөд үхэшгүй мөнх болсон байв. Гэхдээ энэ бие махбодгүй эсвэл хүн байхаа больсон гэсэн үг огтхон ч биш. Харин ч эсрэгээрээ Есүсийн биеийн амилал нь итгэгчдийн биеийн амиллын анхны үр жимс юм хэмээн 1 Коринт 15-р бүлэгт өгүүлдэг. Үүнчлэн энэ нь ирээдүйд бидний бие махбод ямар байхыг бидэнд харуулдаг билээ.

Коринт 15:20-23-р эшлэлд юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

Гэвч Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдын анхны үр жимс мөн. Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ...Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана.. гэжээ (1 Коринт 15:20-23).

Адам анхны бүтээгдсэн хүн байсанчлан Есүс үхлээс амилж, алдаршуулагдсан бие махбодтой болсон анхны хүн байсан. Түүнээс өмнө үхлээс амилуулагдаж байсан хүмүүс бий. Заримыг нь Есүс Өөрөө ч амилуулж байсан. Енох, Елиа хоёр бүр үхлийг үзэлгүй бие махбодтойгоо тэнгэрт одсон байдаг. Гэхдээ эдгээрийн аль нь ч Есүс шиг алдаршуулагдсан, үхэшгүй бие махбодтой болоогүй юм.

Гэхдээ Есүсийн бие одоо алдаршуулагдсан ч бүрэн дүүрэн хүн хэвээр байгаа. Яг л Бурхан бидний биеийг үхэгсдийн амилалд шинэчилсний дараа ч бид бүрэн дүүрэн хүн хэвээр байхтай адил юм.

Есүс нярай хүүхэд байсан. Тэрээр нялх нярай үедээ ээжээсээ бүрэн хамаарч байлаа. Тэр өсөж том болж, мэргэн ухаан, бие хаа нь өссөөр

байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байсан талаар Лук ном өгүүлдэг. Тэр бидний л адил өлсөж, бидний л адил цангаж, Калварийн толгод дээр хүмүүний л адил нас барсан юм. Гэвч үүнээс ч илүүгээр Тэр зөвхөн бүрэн дүүрэн хүн байгаад зогсохгүй бүрэн дүүрэн Бурхан байсан. Есүс зүгээр л жинхэнэ хүн байгаад зогсохгүй төгс төгөлдөр хүн байсан билээ.

-Др. Р. Алберт Мохлер, Жр.

Ингээд бүгдээрээ Есүсийн хүмүүн чанарыг Түүний туулсан амьдралын туршлагаас нь авч үзлээ. Харин одоо Түүний хүмүүн байр суурь буюу үүргийн тухай Элч нарын тунхагт юу гэж заасныг хамтдаа үзэцгээе.

Алба үүрэг

Элч нарын тунхагт Есүсийн алба үүргийн тухай өгүүлсэн байдаг. Энд:

Би Есүс Христэд итгэдэг... гэжээ.

Орчин үед, "Христ" гэдэг үг нь Есүсийн нэр биш харин алба үүргийг илэрхийлдэг үг гэдгийг мэддэггүй итгэгчид олон болжээ. Өөрөөр хэлбэл "Христ" гэдэг нь "хаан" эсвэл "шүүгч" гэдэг үгтэй адил утгатай байдаг.

Бид Есүсийн хүмүүн алба үүргийг хоёр хэсэгт хуваан үзнэ. Нэгдүгээрт, бид "Христ" гэдэг алба үүргийн тухай Хуучин Гэрээнд юу гэж заасныг судална. Хоёрдугаарт, Есүсийн дотор биеллээ олсон энэхүү алба үүрэг нь бидний Эзэний хүмүүн чанарыг хэрхэн харуулж буйг тайлбарлах болно. Ингээд эхлээд "Христ" гэдэг алба үүргийг Хуучин Гэрээнд юу гэж заасныг хамтдаа үзэцгээе.

Хуучин Гэрээний үндэслэл

Англи хэл дээрх "Христ" гэдэг үг нь Грек хэлний христос гэдэг үгийн орчуулга бөгөөд энэ нь Хуучин Гэрээний Еврей хэлний машиах эсвэл "мессиа" буюу "тослогдсон нэгэн" гэсэн утгатай үг юм.

Хуучин Гэрээний цаг үед "тослогдсон нэгэн" гэдэг хэллэг нь Бурхан онцгой үүрэг гүйцэтгэн, Өөртөө үйлчлүүлэхээр томилсон хэн бүхнийг тодорхойлдог өргөн утгатай нэр томьёо байжээ. Жишээ нь, 1 Шастир 16:22 дээр эш үзүүлэгчдийг тослогдсон хүмүүс гэж нэрлэсэн байдаг. Мөн Левит 4:3, 5, 16 зэрэг эшлэлүүдэд тослогдсон тахилч нарын тухай өгүүлсэн нь бий. Мөн 1 Самуел 26:9, 11, 16 дээр Давид Саулыг Израилийн хаан байсан тул Эзэний тослогдсон нэгэн гэжээ.

Левит 21:10-12 дээр тэргүүн тахилчийг тосолж буй тухай өгүүлсэн. Энд:

Ах дүү нар дотроо тосолгооны тосыг толгой дээрээ цутгуулсан, тахилчийн хувцсыг өмсөхөөр ариусгагдсан тэргүүн тахилч ... Учир нь Бурханых нь тосолгооны тосны ариусгал түүний дээр байгаа болой" гэжээ (Левит 21:10-12).

Эндээс харах юм бол тослох ёслолоор хүмүүсийг Бурханд үйлчлэх үйлчлэлд томилдог байсан.

Хуучин Гэрээнд "тослогдсон нэгэн" гэдэг хэллэгийг ашигласан хамгийн чухал тохиолдол бол Израиль болон Иудаг захирдаг Давидын үр удмыг нэрлэсэн явдал юм. Бид үүнийг Дуулал 89:38, 51, Дуулал 132:10, 17, 2 Шастир 6:42 зэрэг эшлэлүүдээс харж болно. Бурхан Давидтай гэрээ байгуулж, үр удмаас нь хэзээ ч мөхөшгүй хаанчлалыг газар дээр байгуулна хэмээн амласан байдаг. Эзэний Давидтай байгуулсан энэхүү гэрээг Дуулал 89:3-4 дээр дүгнэсэн нь бий. Энд:

“Би сонгосон нэгэнтэйгээ гэрээ байгуулсан. Би Өөрийн зарц Давидад тангарагласан. Би чиний үрийг мөнхөд тогтоож, Хаан ширээг чинь бүх үеийнхэнд байгуулна” гэжээ (Дуулал 89:3-4).

Бурхан Давидын үр удамд ийнхүү амласан атал яагаад тэд хаан ширээгээ алдсан юм бол гэж гайхах нь аргагүй. Хариулт нь Бурханы энэхүү гэрээндээ амласан ерөөл нь Давидын үр удам бүр Түүнд дуулгавартай байх гэсэн нөхцөлтэй байсан юм. Гэрээний энэ нөхцөлийн тухай 2 Шастир 6:16, Дуулал 89:30-32, мөн Дуулал 132:12 зэрэг эшлэлд тодорхой дурдсан байдаг. Тиймээс Давидын үр удам Эзэний эсрэг тэрслэхдээ хаан ширээгээ алдсан юм.

Жишээ нь, МЭӨ 922 онд буюу Давидын ач хүү Рехобоамын хаанчлалын үед Бурхан Давидын удмаас арван овгийг тастан авч, Иеробоамд өгсөн байдаг. Энэ үйл явдал 1 Хаад 11-12-р бүлэгт гардаг. Иеробоамыг дагасан аймгууд нь Израилийн хаант улс болж, харин Рехобоамыг дагасан үлдэгсэд нь Иудагийн хаант улс гэж нэрлэгддэг болсон.

Хожим нь МЭӨ 587 онд Давидын удмын Иекониа хаан ширээгээ алдаж, Вавилончуудын эрхшээлд ороход Иудагийн хаант улс ч Давидын гэрээс таслагдсан.

Яг энэ цаг үед олон эш үзүүлэгчид Бурхан агуу "мессиа", "тослогдсон нэгэн"-ийг илгээн хэмээн эш үзүүлж байлаа. Давидын удмын тэр Нэгэн нь агуу хаан болж, Израиль ба Иудаг нэгтгэж, сэргээх болно гэсэн байдаг.

Хуучин Гэрээн дэх Мессиа гэдэг нь хаан буюу Давидын удмын хааныг хэлдэг. Бурхан Давидтай гэрээ байгуулсан. Бурхан энэхүү гэрээндээ Тэрээр хэзээ нэгэн цагт "Бурханы Хүү" буюу Өөртэй нь Эцэг Хүүгийн харилцаатай хааныг босгон, тэрхүү хаан нь Давидын хаан ширээнд мөнхөд хаанчилж, шударга ёс болон зөвт байдлыг тогтооно гэж амласан. Тэгэхээр бид Хуучин Гэрээний Мессиагийн тухай ярьж байна гэдэг нь хааны тухай буюу Бурханы аврал ба чөлөөлөлтийг авчрах жинхэнэ хааны тухай ярьж байна гэсэн үг юм.

-Др. Марк Л. Страус

Хуучин Гэрээний олон олон эш үзүүлэгчид цөллөгөөс амлагдсан нутаг руу удирдах, дахин сэргэсэн үндэстэнд Бурханы агуу ерөөлүүдийг авчрах Давидын удмын Мессиа буюу Христийн тухай зөгнөсөн байдаг. Жишээ нь, Иеремиа 23:5-8, 30:8-9, 33:14-17 зэрэг эшлэлүүдэд үүнтэй холбоотой эш үзүүлэлгүүд бий. Мөн эдгээрийг Зехариа 12-13-р бүлгээс уншиж болно. Иеремиа 23:5-6-р эшлэлийг жишээ болгон сонсоцгооё. Энэ нь:

"Харагтун, Би Давидад зөвт Мөчир ургуулах өдрүүд ирж байна” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Тэрээр хаан болон захирч, мэргэн ухаанаар үйлдэнэ. Энэ газар шударга ёс, үнэн зөвийг үйлдэнэ. Түүний өдрүүдэд Иуда аврагдаж,

Израиль аюулгүй амьдарна. Дуудагдах нэр нь «ЭЗЭН бидний зөвт байдал» юм" гэжээ (Иеремиа 23:5-6).

Хуучин Гэрээ нь энэхүү эш үзүүлэлгүүдээрээ дамжуулан Бурханы ард түмнийг зовлон бэрхшээлээс нь аварч, Бурханы сүр жавхлантай ерөөлд авчрах Мессиаг буюу Давидын удмын тослогдсон хааныг хүсэн хүлээхийг урамшуулдаг.

Бид Мессиагийн алба үүргийн талаарх Хуучин Гэрээний үндэслэлийг үзсэн тул одоо бүгдээрээ Есүсийн дотор биеллээ олсон энэхүү алба үүрэг нь Түүний хүмүүн чанарыг хэрхэн харуулж буйг тайлбарлахад бэлэн боллоо.

Есүс доторх биелэлт

Шинэ Гэрээнд Есүсийг Христ хэмээн 500 гаруй удаа дурдсан байдаг. Тиймээс Христитгэлийн үзлийн үүднээс ч бай, үгүй ч бай Тэр бол Хуучин Гэрээнд зөгнөн хэлсэн агуу Мессиа мөнөөс мөн. Гэвч эргэлзээгээ бүрэн арилгахын тулд Иоханы Сайнмэдээнд Есүсийг "Мессиа" гэж дуудсан хоёр багц эшлэлийг авч үзье. Эдгээр эшлэлд Иохан "Мессиа" гэдэг нь "Христ" гэдэгтэй адил утгатай гэж тайлбарласан байдаг. Үүнд Иохан 1:41, мөн Иохан 5:25-26-р эшлэл ордог. Энэхүү санааг батлахын тулд эдгээрийн зөвхөн нэгийг нь авч үзье.

Есүсийн худаг дээрх эмэгтэйтэй ярьсан яриаг Иохан 4:25-26-р эшлэлээс хамтдаа харцгаая. Энд:

"Тэр эмэгтэй Есүст "Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ. Тэр ирэхдээ бүх зүйлийг бидэнд мэдүүлнэ" гэв. Есүс түүнд "Тэр чинь чамтай ярьж буй Би байгаа" юм гэж айлдав" гэжээ (Иохан 4:25-26).

Есүс энд Өөрийгөө Хуучин Гэрээнд зөгнөсөн Мессиа гэдгээ шууд хүлээн зөвшөөрсөн байна. Иохан энд буй "Христ" бол грек хэлний "месиа" буюу христос юм гэдгийг тайлбарласан. Өөрөөр хэлбэл бид Есүсийг Христ гэснийг харахдаа Хуучин Гэрээнд зөгнөсөн Мессиаг хэлж байна гэж ойлгох хэрэгтэй гэсэн үг юм.

Тэгвэл Есүсийн Мессиа ба Христ байсан нь Түүнийг үнэхээр хүн байсан гэдгийг хэрхэн батлах юм бэ? Бурхан яагаад зүгээр л яруу алдартайгаар газар дэлхий дээр бууж ирээд, хүн төрөлхтнийг аварч болоогүй юм бэ? Эсвэл Тэр яагаад тэнгэр элчээ илгээн, сонгосон үндэстнээ удирдуулж болоогүй вэ?

Тэгэхээр Хуучин Гэрээний эш үзүүлэлгийн дагуу Мессиа нь гарцаагүй хүн байх ёстой байв. Учир нь Тэрээр Давидын удмын хүү байх ёстой шүү дээ. Бурхан Давидтай гэрээ байгуулахдаа түүний удмын нэгэн хүн Израилийг мөнхөд удирдана гэж хэлснийг бид үзсэн. Мэдээжийн хэрэг Давидын үр удам бүгд хүн байсан.

Бурхан гэм нүгэлт хүмүүстэй гэрээгээр дамжуулан харилцаа тогтоодог байсан. Бурхан үүнийг Өөрийн хүслээр хийдэг. Тэрээр үүнийг хийх ямар ч үүрэг хүлээгээгүй. Энэ бол Бурханы Өөрийнх нь санаачилга юм. Өөрийн Хүүгийнхээ зуучлалаар бидэнтэй гэрээ байгуулах нь Бурханы бүрэн эрхт сонголт байв. Харин Бурхан нэгэнт гэрээгээ байгуулсны дараа бол мэдээж гэрээний нөхцөл нь ерөөл ч байсан, хараал ч байсан үүнийгээ заавал биелүүлэх үүрэгтэй болсон. Тэрээр гэрээгээ зөрчих эрхгүй юм.

-Др. Дерек Томас

Тун хачирхалтай сонсогдож байгаа хэдий ч Бурхан үнэхээр Өөрийнхөө тушаалын дагуу Өөртөө үүрэг хариуцлага хүлээлгэдэг. Тэр гэрээ байгуулсан л бол гэрээнийхээ нөхцөлийг заавал биелүүлдэг. Тэрээр Өөрийн гэрээний ард түмнийхээ төлөөх мөнхийн хүслээ гүйцээхийн тулд Өөрөө үүрэг хариуцлага хүлээхийг сонгосон юм. Гэвч Тэрээр гэрээг биелүүлэх үүрэгтэй ч энэ нь Түүний чөлөөт хүсэл тэмүүллийн илэрхийлэл хэвээр байдаг.

-Др. Паул Чан, орчуулга

Бурхан энэхүү Давидтай байгуулсан гэрээгээрээ Өөрийнхөө ард түмнийг аврах Мессиаг илгээх үүргийг Өөрөө Өөртөө хүлээлгэсэн. Тэрхүү Мессиа нь Есүс байсан юм.

Хоёр дахь шалтгаан бол зөвхөн Давидын удам л ард түмнийхээ төлөөх эвлэрүүллийн золиос болж чадна гэдэг нь байв. Еврей 2:14-17 дээр Мессиа нь хүн байх ёстой гэдгийг тодорхой өгүүлдэг. Үүнээс гадна Исаиа 53-р бүлэгт бүр Давидын хүү л эвлэрүүллийг хийх ёстой гэсэн шаардлагыг нэмсэн нь бий. Мессиа хүн байх ёстой гурав дахь шалтгаан бол Тэрээр хоёр дахь Адам байх учиртай байсан нь юм. Өөрөөр хэлбэл Тэрээр Адамын алдааг залруулах ёстой байлаа.

Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ Адамыг бүх үндэстний тэргүүн болгож, хүн төрөлхтнийг газар дэлхийг Бурханы хаант улс болгон өөрчлүүлэхээр томилсон. Гэвч Адам нүгэл үйлдэж, хүн төрөлхтнийг ч гэмд унагасан. Үүнээс болж бид хүлээсэн үүргээ биелүүлэх чадваргүй болсон юм. Энэ тухай Эхлэл 1-3-р бүлэгт өгүүлдэг бөгөөд Ром 5:12-19-р эшлэлд үүний гүн гүнзгий ач холбогдлыг тайлбарласан байдаг. Хуучин Гэрээний түүхийн номуудад нүгэлд унасан хүн төрөлхтөн олон зууны туршид Бурханы хаант улсыг байгуулахаар чармайсан ч бүтэлгүйтсээр ирснийг бичиж тэмдэглэсэн нь бий.

Гэсэн ч Бурхан Эцэг шаардлагаа хэзээ ч өөрчлөөгүй юм. Хүн төрөлхтөн Бурханы хаанчлалыг байгуулах үүрэгтэй хэвээр байв. Тиймээс эцэст нь Эцэг энэ асуудлыг шийдэхийн тулд Өөрийн Хүүг илгээсэн. Хүү бидний өмнөөс хаанчлалыг байгуулахаар ирсэн. Гэвч Тэрээр ийнхүү бидний өмнөөс хаанчлалыг байгуулахын тулд Өөрөө хүн байх ёстой байлаа. Тэрээр зөвт амьдрал, золиос бүхий үхэл, ялгуусан амилал ба тэнгэр дэх залралаараа Адам болон бусад бүх хүний алдааг залруулсан юм. Тэрээр хүн төрөлхтний хоёр дахь Адам болсон. Бид итгэлээрээ Есүстэй нэгдэх үед Түүний амжилт бидний амжилт болж, Түүний хүч бидний хүч чадал болдог. Тэгээд бидний Бурханы хаант улсыг байгуулах эрхэм бас чухал үүрэг эргэн сэргэдэг билээ.

Энэ хүртэл бид Есүсийн хүмүүн чанарын хүрээнд Түүний хүмүүн амьдралын туршлага болон Мессиа буюу Христийн хүмүүн алба үүргийг нь олон талаас нь ярилцлаа. Тэгэхээр одоо бүгдээрээ Есүсийн хүмүүн болон бурханлаг мөн чанарын хоорондын харилцааны талаар үзэхэд бэлэн боллоо.

МӨН ЧАНАР

Есүс хүмүүн мөн чанартай байсан гэдэг нь Түүнд хүний бие махбод, хүний сүнс, сэтгэл гэх зэрэг хүнд байх ёстой үндсэн шинж чанар, онцлог талууд байсан гэсэн үг юм.

Сүм чуулганы түүхийн туршид Есүсийн хүмүүн чанарын талаар теологийн олон маргаан тэмцэл өрнөсөөр ирсэн. Тэр үнэхээр бүхий л талаараа жинхэнэ хүн байсан уу? Тэрээр үнэхээр жинхэнэ бие махбод, цуснаас бүрдсэн хүн байсан уу? Эсвэл зүгээр л хүн шиг харагддаг байсан уу? Тэрээр хүмүүний сүнстэй байсан уу? Эсвэл Түүний бурханлаг оршихуй нь хүмүүний хоосон биед оршиж байсан уу? Энэ мэт асуултууд хэт онолын, нууцлаг, магадгүй бүр тийм ч чухал биш юм шиг санагдаж болох юм. Гэвч Есүсийн хүмүүн мөн чанарын талаарх маргаан нь чуулганыг хагаран бутаргах аюул дагуулдаг. Энэ нь олон теологийн зөвлөлүүдийн гол сэдэв, тоо томшгүй тэрс үзлүүдийн бүдрэх чулуу болсон байдаг. Өнөөдөр ч хүртэл Христийн хүмүүн чанарын талаарх буруу ойлголтууд Сайнмэдээг гуйвуулсаар байна. Тиймээс Христитгэгч хүн бүр Есүсийн хүмүүн мөн чанарын талаарх анхан шатны мэдлэг ойлголттой байх нь чухал юм.

Харин Христийн үнэн зөв теологи нь Есүсийг бүх талаараа бүрэн дүүрэн хүн байсан гэдгийг тууштай нотолсоор ирсэн. Тэрээр бие махбодтой, сүнстэй байсан бөгөөд өвдсөн, шархадсан, үхсэн. Тэр энгийн л хязгаарлагдмал бодит бие махбодтой байсан.

Түүний тухай ийнхүү ярих үед байдал дорхноо л төвөгтэй болж хувирдаг. Учир нь Есүс бусад хүмүүсээс зарим чухал тараараа ялгаатай байдаг. Нэг л жишээ дурдахад Есүс төгс хүн байсан бол бусад бүх хүн алдаа дутагдалтай байдаг. Үүнээс үүдэн Есүс болон хүмүүсийн хооронд маш олон ялгаа гарч ирсэн. Жишээ нь, хүн бүр гэм нүгэлтэй. Энэ талаар бид 1 Хаад 8:46, Дуулал 130:3, Дуулал 143:2, Ром 5:12, Галат 3:22 гэх мэт олон эшлэлээс харж болно. Тэгвэл Ром 3:10-12-р эшлэлийг жишээ болгон хамт сонсоцгооё. Энд:

“Зөвт хүн алга, ганц ч алга. Ухаардаг нь алга. Бурханыг эрэн хайдаг нь ч алга. Бүгд гажиж, цөмөөрөө хэрэггүй болжээ. Сайныг үйлддэг нь алга. Бүр ганц ч алга” гэдэг (Ром 3:10-12).

Харин Есүс өөр байсан. Тэр нүгэлгүй төрж, төгс гэм зэмгүй амьдралаар амьдарсан. Библид Есүсийн гэм нүгэлгүй байдлын тухай Еврей 4:14-15, 9:14 зэрэг эшлэлүүдэд онцгойлон бичсэн байдаг. Тэгвэл бид энэ ойлголтыг Түүний жинхэнэ, бүрэн дүүрэн хүмүүн мөн чанартай нь хэрхэн уялдуулах вэ? Тэгэхээр хамгийн энгийн хариулт бол гэм нүгэл үйлдэх нь, тэр бүү хэл нүгэл үйлдэх чадвар нь хүний үндсэн чанар биш юм.

Бурхан анхнаас нь хүн төрөлхтнийг нүгэл үйлдэх чадвартай бүтээсэн нь үнэн. Эхлэл 3-р бүлэгт Адам Ева хоёр сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идсэн нь үүнийг баталдаг. Гэвч Адам Ева хоёр гэм нүгэлд унахаасаа өмнө хүн хэвээр байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тиймээс гэм нүгэлгүй хүн байх боломжтой. Үнэндээ бид нас барсныхаа дараа тэнгэрийн улсад очих үедээ гэм нүгэл үйлдэх чадваргүй болно гэж Еврей 12:23-р дээр хэлсэн байдаг. Гэсэн ч бид хүн хэвээрээ л байх болно. Унасан энэ дэлхийд гэм нүгэл биднийг тодорхойлдог ч тэнгэрт тийм биш байх болно. Ийм учраас гэм нүгэл бол хүмүүний үндсэн мөн чанар биш юм. Есүст хүн байхад чухал шаардлагатай бүхий л шинж чанар болон онцлог талууд байсан гэж хэлсэн нь ийм учиртай.

Есүсийн бусдаас ялгарах нэг онцлог бол Тэрээр хүмүүн болон бурханлаг мөн чанартай цорын ганц хүн байсан явдал юм. Түүнээс бусад бүх хүн зөвхөн хүмүүн мөн чанартай байдаг гэсэн үг. Тэгвэл Есүс хүмүүн ба бурханлаг мөн чанарыг зэрэг агуулж байснаараа Бурхан бас хүн байсан. Христийн энэхүү хоёр мөн чанар Түүний бодгаль дотор хэрхэн нэгдэж байсан тухай Библид тодорхой заагаагүй. Энэ нэгдлийг тайлбарлахад бэрхшээлтэй байсан тул анхны чуулганд олон маргааныг үүсгэж байв. Гэсэн хэдий ч

чуулган Библид дүрсэлснээс хэтрүүлэхгүйгээр Христийн нэг бодгаль, хоёр мөн чанарыг баталгаажуулсан үг хэллэг дээр тогтож чадсан байдаг.

Христийн бодгальд хүмүүн ба бурханлаг мөн чанар хоёул оршдог гэдгийг илэрхийлэхдээ бид "гипостатик нэгдэл" гэдэг техникийн хэллэг ашигладаг. Өнөө цаг үед амьдарч байгаа бидэнд энэ нэр томъёо хачирхалтай сонсогдож болох ч чуулганы эхэн үед хэрхэн ашиглаж байсныг нь мэдэх юм бол ойлгоход хялбар байх болно. Чуулганы эхэн үед бидний хэлдгээр бодгаль буюу ялангуяа Гурвалын бодгалийг илэрхийлэхдээ "гипостасис" гэдэг үгийг түгээмэл ашигладаг байжээ.

Жишээ нь, Дөрөвдүгээр зууны чуулганы эцэг Базил Ариун Сүнсний талаарх бүтээлийнхээ 18-р бүлэгт гипостасис гэдэг үгийг дараах байдлаар ашигласан байна. Энд:

"Цорын ганц Бурхан Эцэг, цорын ганц Хүү, цорын ганц Ариун Сүнс байна. Бид гипотасис бүрийг тус тусад нь тунхагладаг" гэжээ.

Базилын хэлсэн энэхүү үг бид "Бурханы бодгаль бүрийг тус тусад нь тунхагладаг" гэдэгтэй ижил утгатай юм. Тэгэхээр гипостатик нэгдлийн онол сургаал нь Хүү Бурханы нэг бодгаль буюу гипотасис доторх хүмүүн болон бурханлаг мөн чанарын нэгдлийг хэлж байна. Товчхондоо энэ нь:

Есүс бол өөр өөрийн шинж бүхий хоёр тусдаа мөн чанартай (бурханлаг ба хүмүүн мөн чанар) нэг бодгаль юм гэсэн үг.

Хүү Бурхан бүхий л бурханлаг шинжийг Өөртөө агуулсан, бүрэн дүүрэн бурханлаг мөн чанартай байсан. Харин эхийн хэвлийд олдож, хүн болж төрөхдөө махбод ба сүнс гэсэн хүмүүнд байдаг үндсэн бүхий л шинж чанарыг Өөрийн бодгальд нэмсэн гэсэн үг.

Шинэ Гэрээнд гипостатик нэгдлийн тухай хэлсэн нэг тохиолдол бол Филиппой 2:5-7-р эшлэл юм. Энэ нь:

"...Христ Есүст... Хэдийгээр Тэрээр Бурханы дүр байсан ч... Харин Өөрийгөө юу ч үгүй болгон Боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ" гэжээ (Филиппой 2:5-7).

Есүс бүрэн дүүрэн бурханлаг мөн чанартай Бурхан байсан гэдгийг Паул энд тодорхой хэлсэн байдаг. Тэгээд хүний биеийг өмсөн биежихдээ Өөрийн бурханлаг мөн чанар дээрээ хүмүүний мөн чанарыг нэмсэн. Паул энд Есүс "Өөрийгөө юу ч үгүй болгосон" буюу шууд утгаараа "Өөрийгөө хоосолсон" гэж хэлсэн нь заримдаа Христитгэгчдийг төөрөгдүүлдэг.

Зарим нь үүнийг Есүс Өөрийн суу алдраа, түүгээр ч зогсохгүй бурханлаг мөн чанараа хүртэл орхисон гэж буруугаар ойлгодог. Гэвч бид өмнөх хичээлүүдээр үзсэнчлэн энэ нь боломжгүй юм. Бурханы мөн чанар бол хувиршгүй. Бурхан Өөрийн шинж чанаруудын алиныг нь ч орхиж, мөн чанар нь жаахан ч хорогдох боломжгүй билээ.

Аз болоход, Паул энэ өгүүлбэрийнхээ утга санааг хоёр зүйлээр тодорхой тайлбарласан байдаг. Тэрээр Түүнийг боолын дүрийг авч, хүнтэй адил болсон гэжээ. Эдгээр нь Есүс хэрхэн "юу ч үгүй болсон" буюу "Өөрийгөө хоосолсон" болохыг тайлбарладаг. Тодруулбал Есүс бурханлаг мөн чанараа гээснээрээ бус харин хүний мөн чанарыг нэмж авснаараа Өөрийгөө хоосолсон гэсэн үг. Хүний мөн чанар Түүний бурханлаг мөн чанарыг орлоогүй, харин ердөө бурханлаг алдар сууг нь халхалсан хэрэг байв.

Гипостатик нэгдлийн хамгийн алдартай тунхаглал бол МЭ 451 онд бага Азийн умард хэсэгт орших Калседон хотын зөвлөлийн гаргасан тунхаглал байж болох юм. Калседоны зөвлөл Христийн бодгаль ба мөн чанаруудын талаарх уламжлалт онол сургаалаа хамгаалж, энэ асуудалтай холбоотой хэд хэдэн тэрс үзлийг няцаасан байдаг.

Зөвлөлийн гаргасан тунхаглал нь Калседоны тунхаг, "Бэлгэдэл", эсвэл Калседоны тодорхойлолт зэрэг нэрээр танигдсан байдаг. Тэгвэл үүний нэг хэсгээс хамтдаа сонсоцгооё. Энэ:

"Бидний Эзэн Есүс Христ бол бурхан байдлаараа ч төгс, хүмүүн байдлаараа ч төгс, жинхэнэ Бурхан ба сэтгэн боддог оюун ухаан, бие махбод бүхий жинхэнэ хүн... бүхий л талаараа бидэнтэй адил боловч гэм нүгэлгүй... хоёр мөн чанараар будилаангүй, өөрчлөлтгүй, хуваагдалгүй, салангид биш байдлаар оршдог; Түүний ялгаатай мөн чанарууд нь нэгдлээс болж үгүй болоогүй, харин мөн чанар тус бүрийн шинжүүд нь нэг бодгаль, нэг биед хадгалагдан зэрэгцэн оршдог" гэжээ.

Калседонын тунхаг нь техникийн үг хэллэг ихтэй. Гэхдээ бид энэ тунхгийг хоёр гол санаанд хуваан дүгнэж болно. Эхнийх нь Есүс бол нэг л бодгальтай гэсэн санаа юм. Тэрээр Өөрийнхөө биед бурханлаг бодгалийг урин оруулсан хүн шиг хоёр бодгаль, хоёр оюун ухаантай байгаагүй. Мөн Тэрээр Бурханы бодгаль хүмүүний бодгальтай нэгдсэн мэт хоёр өөр бодгаль ба оюун ухаан хосолсон нэг бодгаль ч биш юм. Тэр бол Бурханы Хүү гэх нэг л ижил мөнх бодгаль байсаар байсан, одоо ч байгаа билээ.

Есүст хүмүүн ба бурхан чанар гэсэн хоёр өөр чанар нэгэн зэрэг оршин байсан юм. Эцэгийн мөн чанар бүрэн дүүрэн бурханлаг, хүмүүний мөн чанар бүрэн дүүрэн хүнийх байдагтай адил энэ хоёр мөн чанар хоёулаа Түүнд бүхэлдээ тийнхүү бүрэн дүүрнээр оршин байсан. Есүст бурхан чанарын үндсэн шинж хийгээд хүмүүн чанарын үндсэн шинжүүд бүгд байсан юм.

Түүнээс гадна Есүсийн хоёр мөн чанар нь бие биеэсээ ялгаатай. Түүнд бурхан болон хүмүүн чанарыг хослуулсан холимог мөн чанар байдаггүй. Мөн Түүний хүмүүн чанарууд нь бурхан чанаруудад нь саад болдоггүй. Эсвэл Түүний бурхан чанарууд нь хүмүүн чанарыг нь сайжруулдаггүй. Мөн чанар бүр нь өөрчлөгдөхгүй хэвээр байдаг.

Еврейчүүдэд бичсэн захидалд Бурхан ба хүн хоорондын зуучлагч, агуу тэргүүн тахилч нь бүрэн дүүрэн Бурхан, бүрэн дүүрэн хүн байх нь хэчнээн чухал болохыг онцлон тэмдэглэсэн нь надад маш сонирхолтой санагддаг. Тэр бол мөнхийн Бурхан, үгийнхээ хүч чадлаар бүхнийг тогтоосон Бүтээгч. Тэр бол бүрэн дүүрэн Бурхан. Еврей номд хэлснээр бидэнд бүрэн дүүрэн хүн болох тэргүүн тахилч хэрэгтэй учраас Тэрээр яг л бидэнтэй адил махбод ба цустай болж ирсэн. Тэр бидний ах. Хүмүүний мөн чанарыг хуваалцдаг Тэрээр бидний төлөө зуучилж чадна. Тэрээр сорилт, зовлон бэрхшээлийг бүрэн дуулгавраар даван гарсан Нэгэн. Тэр бол хүн хэрхэн соригддог болохыг амсаж туулсан Нэгэн. Тиймээс бидний ах болсон хүмүүн тэргүүн тахилч бидэнд хэрэгтэй юм. Мөн бидний төлөө зуучлах, үүрд мөнхөд амьдрах тэнгэрлэг тэргүүн тахилч хэрэгтэй. Гэтэл энэ хоёр хоёулаа Есүс Христийн нэг бодгаль дотор байсан юм шүү дээ.

-Др. Деннис И. Жонсон

Христийн хүмүүн чанар нь Түүнийг дагаж амьдрахад маань олон талын нөлөө үзүүлдэг. Бурхан болон бидний хооронд ганц хүмүүн зууч бий гэж Паул 1 Тимот 2:5 дээр хэлсэн байдаг. Тэр зуучийн үхлээр дамжуулан бид уучлагдаж, Эцэгтэй бүрэн эвлэрсэн амьдралаар амьдарч чаддаг. Паул Ром 5:12-19 дээр дурдсанчлан хоёр дахь Адам болох Есүс Өөрт нь итгэдэг хүмүүсээр шинэ хүн төрөлхтнийг бий болгож, бүтээлийн доторх бидний нэр хүнд, эрхэм үүрэг бүхий байр суурийг сэргээсэн. Үүний үр дүнд бид одоо Бурханы тааламжит замаар амьдарч, энэ дэлхийг Түүний тэнгэрлэг хаанчлалтай адил болгон өөрчлөх хүч чадалтай болсон. Бид амьдралдаа зовлон бэрхшээл, гэм нүгэлдээ шаналах үедээ нигүүлслийн хаан ширээний өмнө итгэлтэйгээр очиж чадах билээ. Ингэхдээ бид бүрэн дүүрэн хүмүүн болсон Аврагч маань бидний өвчин шаналал, сул дорой байдлыг ойлгож, өрөвдөн энэрдэг гэдгийг мэддэг. Тэрээр зовлонг маань нимгэлж, зан хандлагыг маань хэлбэржүүлж, мөнх шагналыг маань өсгөж өгнө гэдэгт итгэдэг. Эдгээр нь Христийн хүмүүн чанар бидний амьдралд нөлөөлдөг тоо томшгүй олон арга замуудын хэдхэн нь л юм.

Энэ хүртэл бид Есүс Христийн бурхан ба хүмүүн чанарын тухай үзлээ. Тиймээс одоо бид Элч нарын тунхаг дахь Христийн үйлсийн тухай судлахад бэлэн боллоо.

ҮЙЛ ХЭРЭГ

Сүүлийн хэдэн зуун жилийн хугацаанд теологичид Есүсийн үйл хэргийн талаарх хоёр санааг ярих нь түгээмэл болсон. Нэгдүгээрт, Тэрээр Өөрийгөө даруу дорд болгосон явдал юм. Тэрээр мөхөс хүмүүний мөн чанарыг Өөртөө өмсөн, нүгэлд унасан хүн төрөлхтнийг аврахын тулд дэлхий дээр зовлон эдэлж, Өөрийгөө дорд болгон даруусгасан. Хоёрдугаарт, Түүний өргөмжлөгдсөн үйл хэрэг юм. Бурхан Эцэг Христийн далдлагдсан тэнгэрлэг сүр жавхланг ил болгож, Түүнд алдар нэр, магтаал хүндлэлийг нэмж өгсөн. Энэ ойлголтуудын тухай Элч нарын тунхагт ил тодорхой бичээгүй ч эдгээр нь Есүсийн үйл хэргийн тухай ойлгоход бидэнд маш их тустай байдаг.

Энэхүү хичээлээр бид Есүсийн үйл хэргийн тухай үзэхдээ юуны өмнө Түүний дорд болсон тухай буюу Түүний сүр жавхланг нуун далдалсан зүйлсийн талаар ярилцах болно. Дараа нь бид Түүний өргөмжлөгдсөн тухай буюу Түүний сүр жавхланг илчилж, хожим илүү их алдар сууг авчирсан үйл хэргийнх нь тухай үзэх болно. Ингээд одоо бүгдээрээ Христ газар дэлхий дээрх үйлчлэлийнхээ үед хэрхэн дорд болсон тухай эхлээд үзэцгээе.

Дорд болсон нь

Есүсийн дорд болсон үйл хэргийг Элч нарын тунхгийн дараах мөрүүдэд дурдсан байдаг:

**[Тэр] Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариас мэндэлсэн,
Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад
Үхэгсдийн орон руу явсан...**

Эдгээр үйл хэрэг бүрд Бурханы Хүү сүр жавхлангаа нуун, далдалж, зовлон шаналал, доромжлолыг Өөртөө авсан байдаг. Хүүгийн бурханлаг мөн чанар нь хуврашгүй тул дорд болох боломжгүй. Тиймээс Түүний дорд болсон нь хүмүүн мөн чанарт нь л хязгаарлагдаж байв. Гэсэн ч Түүний хүмүүн мөн чанар нь Түүний бодгальтай нь төгс нэгдмэлээр оршин байсан тул бурханлаг бодгаль нь ч мөн дорд болохыг хамт ассан гэсэн үг юм.

Энэхүү хичээлээр бид Есүсийн дорд болсон үйл хэргийг Түүний биежилт ба зовлон шаналал гэсэн хоёр хэсэгт хувааж үзнэ. Ингээд эхлээд энэ дэлхийд хүн болж ирсэн Түүний биежилтийн тухай үзэцгээе.

Биежилт

Энэхүү "Биежилт" гэдэг теологийн нэр томъёо нь Есүс хүмүүн мөн чанарыг бүрэн авсан гэсэн үг юм. Шууд утгаараа "биежилт" гэдэг нь "махбодтой болох", өөрөөр хэлбэл, хүмүүн биетэй болох гэж тайлбарлаж болно. Гэвч бидний өмнө үзсэнчлэн Христитгэлийн теологид Есүсийг мөн хүмүүн сэтгэл зүрхтэй болсон гэж үздэг. Тиймээс энэхүү биежилт гэдэг нь Түүний хүмүүн мөн чанарыг бүхэлд нь хэлж байгаа хэрэг юм. Бичвэрт Христийн биежилтийн талаар Иохан 1:1, 14, Филиппой 2:6-7 болон Еврей 2:14-17 зэрэг олон эшлэлд дурдсан байдаг.

Иохан 1:1-р эшлэл бол үнэндээ "биежилт" гэдэг нэр томъёоны эх сурвалж гэж хэлж болно. Иохан энэ эшлэлд юу гэж хэлснийг сонсоцгооё. Энэ нь:

"Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан, Үг Өөрөө Бурхан байсан...Үг нь махбод болж, бидний дунд оршин..." гэжээ (Иохан 1:1, 14).

Иохан Бурханы Хүүг "махбод болсон" буюу энэ нь шууд утгаараа биежилтийг зааж байгааг анзаараарай. Иоханы гол санаа бол Есүс жинхэнэ хүмүүний бие махбод бүхий жинхэнэ хүмүүний мөн чанарыг авсан гэсэн санаа юм.

Элч нарын тунхаг дахь Есүсийн биежилттэй холбоотой үйл хэргүүд гэвэл Түүний эхийн хэвлийд бүрэлдсэн хийгээд мэндэлсэн явдал юм. Бид өмнө эдгээр үйл явдлуудыг Есүсийн удам угсаатай холбон, эдгээр нь хүмүүн чанарыг нь хэрхэн баталдаг тухай үзсэн. Бид энэ удаа ч мөн эдгээр үйл явдлуудын тухай авч үзэх боловч Есүсийн Мессиагийн үйл хэргийн талаас нь суралцах болно. Яагаад биежилт нь тийм чухал байсан бэ? Үүгээрээ Есүс юуг гүйцэлдүүлсэн юм бэ?

Есүсийн биежилт дор хаяж гурван зүйлийг гүйцэлдүүлсэн байдаг. Нэгдүгээрт, энэ нь Хүү Бурханд Давидын удмын хаан болох хууль ёсны эрхийг өгсөн. Хоёрдугаарт, биежилт нь Түүнд үр нөлөөтэй тэргүүн тахилч байхад хэрэгтэй өршөөл, өрөвдөх сэтгэлийг өгсөн. Гуравдугаарт, биежилт нь Есүсийг гэм нүглийн төлөөх эвлэрүүллийн золиос болоход зайлшгүй хэрэгтэй зүйл байв. Одоо эдгээр гурван санааг товчхон авч үзье. Эхлээд Давидын удмын хаан заавал хүн байх ёстой байсан талаар харцгаая.

Бурхан Давидад өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд Мессиа нь хүн байх ёстой байсныг бид өмнө нь ярьсан. Тиймээс яг энэ утгаараа Есүсийн биежилт нь Түүнд хэрхэн Давидын хаан ширээг залгамжлах эрхийг өгсөн болохыг бид харах болно. Энд бид Давидын хаан ширээг өвлөх хууль ёсны эрхийг зөвхөн хөвгүүд нь өвлөн авах ёстой гэдэг асуудалтай тулгардаг. Тиймээс Есүс Давидын удмын эцэгтэй байснаар л Давидын хаан ширээг залгамжлах эрхтэй болно гэсэн үг.

Энэ асуудлыг шийдэхийн тулд Есүс Иосефын сүйт бүсгүй Мариагаас хүмүүн биетэй болж мэндэлсэн. Есүсийн угсаа гарлын тухай Матай 1, Лук 3-р бүлэгт бичсэний дагуу Иосеф бол Давидын шууд хууль ёсны удмын хүн байсан. Тэгээд Иосеф Мариатай гэрлэж, Есүсийн эцэг болсноор Есүс Мессиа хаан болох эрхтэй Иосефын хууль ёсны удам угсаа болсон юм.

Биежилт нь Хүү Бурханд Давидын удмын хаан байх хууль ёсны эрхийг өгснөөс гадна ард түмийнхээ төлөөх үр нөлөөтэй тэргүүн тахилч байхад хэрэгтэй өршөөл ба өрөвдөх сэтгэлийг ч мөн өгсөн юм.

Есүс хүн болсноор бидний сул дорой байдлыг ойлгож, өрөвдөх чадвартай тэргүүн тахилч болох боломжтой болсон гэж Библи бидэнд заадаг. Энэ нь Тэрээр хүн байх нь ямар байдгийг, юу туулдгийг бүрэн дүүрэн мэддэггүй байхаас хавь илүү үр нөлөөтэй тахилч болсон гэсэн үг юм. Энэ нь ч бидэнд олон талаар илэрхий ойлгомжтой байдаг. Есүс гэм нүгэлд унасан энэ дэлхий ертөнцөд бидний туулдагтай ижил зовлон бэрхшээлийг Өөрийн амьдралаар туулсан. Тиймээс махбодтой Бурхан Тэрээр гэм нүгэлд унасан дэлхийн хүн бүрийн туулдаг шаналал харуусал, урам хугаралт, урвалт, сэтгэлийн шархыг ойлгодог юм. Эдгээр нь Түүний хувьд хий хоосон онол, сансар огторгуйн гүнд зогсоод, мөнх оршихуйн тоосонд дарагдсан өнгөрснийг хараад таамагласан зүйл биш. Харин Тэрээр бидэн шиг дорой махбод ба цустай болж, Өөрийн биеэр мэдэрч туулсан зүйлс юм.

-Др. Ж Лигон Дункан III

Еврей номын бичээч Еврей 2:17-18 дээр Есүсийн биежилтийг энэ талаас нь тайлбарласан байдаг. Тэрээр юу гэж хэлснийг сонсоцгооё:

[Есүс] Тиймээс Бурханы өмнө өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч болж, хүмүүсийн нүглийн эвлэрүүллийг хийхийн тулд Тэр бүх талаараа ах дүү нартайгаа адил болох ёстой байв. Учир нь Тэр Өөрөө соригдон зовлон эдэлсэн тул соригдогсдод тусалж чадна" гэжээ (Еврей 2:17-18).

Биежилт нь Есүст Давидын удмын хаан болох эрхийг өгч, үр нөлөөтэй тэргүүн тахилч болгосноос гадна Өөрийн ард түмний гэм нүглийн төлөөх эвлэрүүллийн тахил болох боломжийг олгосон юм.

Есүс Өөрийн ард түмнийхээ оронд амиа өгөхийн тулд хүн байх шаардлагатай байсан тухай бид энэхүү хичээлийнхээ эхэнд ярилцсан. Тэгвэл эвлэрүүллийг хийхийн тулд Түүний хүмүүн чанар яагаад чухал байсан юм бол? Бурхан хүмүүний гэм нүглийн хөлс бол хүмүүний үхэл гэж үзсэн нь үүний хариулт билээ. Энэ талаар Эхлэл 2:17, Ром 5:12, 6:23, Иаков 1:15 гэх мэт олон эшлэлд заасан байдаг. Адамаас эхлэн гэм нүгэл бүх хүн төрөлхтөнд тархаж, энэ нь хууль ёсны шийтгэл болох хүмүүний үхлийг авчирсан. Тиймээс зөвхөн жинхэнэ мах цустай хүмүүний үхэл л Бурханы шаардлагыг хангаж чадах байсан юм

Паул Ром 5:15-19 дээр Есүсийн хүмүүн чанарыг бидний авралтай холбон хэрхэн тайлбарласныг сонсоцгооё. Энд:

"Хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж олон хүн үхсэн бол, тэгэх тусмаа Бурханы нигүүлсэл болон Есүс Христ гэгч ганц Хүний нигүүлслээр ирсэн бэлэг нь олон хүнд бялхсан юм... Учир нь нэг алдаа зөрчлийг дагасан шүүлт нь ял дагуулсан бол олон алдаа зөрчлийг дагасан бэлэг нь зөвтгөл дагуулсан юм. Ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжин үхэл нь ноёрхсон юм бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялаг ба зөвт байдлын бэлгийг дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дотор ноёрхоно... Учир нь ганц хүний дуулгаваргүйгээс болж олон хүн нүгэлтэн болсны адил Ганцын дуулгавраас болж олон хүн зөвт болгогдоно" гэжээ (Ром 5:15-19).

Паул энд Есүсийн хүмүүн зөвт байдал бол Адамын гэм нүглээс салахад зайлшгүй хэрэгтэй зүйл байсан гэдгийг дахин дахин онцолсон байна. Адамын үйлдсэн гэм бурууг засахын тулд Есүс хүн байх ёстой байсан гэдгийг Паул маш тодорхой болгож өгчээ. Бурханы хүн төрөлхтөнд оноосон шийтгэлийг үүрэхийн тулд, Өөрийнхөө зөвт байдлыг хүн төрөлхтөнд түгээхийн тулд Есүс хүн болохоос өөр арга байгаагүй.

Консерватив, эвангелийн Христитгэгчдийн хувьд бид заримдаа Христийн бурханлаг чанарыг хэтэрхий чухалчлаад, Түүний хүмүүн чанар биднийг авардаг гэдгийг мартчих гээд байдаг. Есүс жинхэнэ хүн болсон учраас л бидний нүглийн улмаас зовлонг эдэлж, амиа өгөх боломжтой болсон. Тиймээс Есүсийн хүмүүн чанар бидний авралд чухал ач холбогдолтой билээ.

-Др. Марк Л. Страус

Ингээд бид Есүсийн биежилтийн талаарх ойлголттой болсон тул одоо элч нарын тунхагт бичигдсэн Түүний дорд болсон үйл хэргийн хоёрдох хэсэг болох зовлон шаналлынх нь тухай хамтдаа судалцгаая.

Зовлон шаналал

Энэхүү "зовлон шаналал" теологийн хэллэг нь Грек хэлний пасхо буюу "зовох" гэдэг үйл үгнээс гаралтай. Энэ үг нь Есүс баригдсан оройноосоо эхлэн зовж шаналан, нас барсныг илэрхийлдэг. Есүсийн зовлонгийн талаар Элч нарын тунхагт дараах зүйлсийг өгүүлдэг. Энд:

**"Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад Ү
хэгсдийн орон руу явсан" гэжээ.**

Ихэнх Христитгэгчид Есүсийн баригдан, зовж тарчилж, загалмайд цовдлогдсон түүхийг сайн мэддэг. Тиймээс энэ тухай дэлгэрэнгүй ярихаас илүү Есүс эдгээр үйл явдлуудыг өөртөө зөвшөөрсөн учир шалтгаанд анхаарлаа хандуулцгаая.

Есүсийн зовлонгийн тухайд энэ нь Есүст дуулгавартай байдлыг зааж, Түүнийг Бурхан Эцэгт даатгахад чухал ач холбогдолтой байсан хэмээн Бичвэрт тайлбарласан байдаг. Еврей 5:8 дээрээс энэ тухай харж болно. Энд :

"[Есүс] Тэрээр Хүү нь байсан хэр нь зовсон зүйлсээсээ дуулгавартай чанарт суралцсан" гэжээ (Еврей 5:8).

Мөн 1 Петр 2:20-21 дээр Петр ийнхүү өгүүлсэн:

"Харин та нар зөвийг үйлдээд зовохдоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы өмнө нигүүлсэл юм. Учир нь та нар үүнд дуудагдсан билээ. Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн" гэжээ.(1 Петр 2:20-21).

Христ зовлон шаналлаараа Эцэгийн хүслийг биелүүлж, Эцэгт Өөрийгөө бүрэн тушаасан. Тэрээр Эцэгийг төгс дуулгавартай дагаснаар одоо бидэнтэй өгөөмрөөр хуваалцдаг тэрхүү мөнхийн шагналаа хүлээн авсан юм.

Пилатын тушаалаар Христэд оногдсон шийтгэл нь зовлон шаналлаар дуусчхаагүй. Харин Түүнийг загалмайд цовдлогдон, амиа алдахад хүргэсэн юм. Энэ бол Христийн дорд болсон үйл хэргийн хамгийн сайн танигдсан хэсэг бөгөөд сайн шалтгааны төлөө байсан. Энэ нь Түүний үхэл бидний гэм нүглийг цагаатгаж, бидний авралыг гүйцэлдүүлсэн явдал юм.

Нүглийн төлөөх Эзэн Есүсийн үхэл нь (Шинэ Гэрээний туршид ингэж танилцуулсан байдаг) зорилгоо биелүүлсэн гэж хэлж болно. Учир нь Тэр бидний гэм нүглийн шийтгэлийн орлуулга болсон юм. "Орлуулга" гэдэг нь бидний байрыг эзэлсэн гэсэн үг. "Шийтгэл" гэдэг нь Бурханы Хуулийг зөрчсөнийхөө улмаас бидний амсах ёстой байсан шийтгэлийг Тэрээр Өөртөө авснаараа шүүлтийг амссан гэдгийг заадаг. Хуулийг нь зөрчвөл шийтгэл зайлшгүй гэдгийг Бурхан анхааруулсан. Энэ бол Бурханы мөн чанар юм. Үнэндээ энэ нь Бурханы ариун байдал бөгөөд Бурханы энэ мөн чанар нүглийг шийтгэлгүй орхидоггүй. Гэсэн ч Бурханы төлөвлөсөн авралын гайхамшигтай, ухаалаг, хайр энэрлийн арга зам нь тэрхүү шийтгэлийг бидний мөрөн дээрээс авч, гэм зэмгүй, өө сэвгүй Хүүгийнхээ мөрөн дээр тохсон явдал байв. Хүү нь Хуучин Гэрээний туршид шаардагдаж байсан өө сэвгүй амьтнаар өргөх тахилын шаардлагыг ийнхүү биелүүлсэн юм.

-Др. Ж.И.Пакер

Элч Паул загалмайн цовдлол бол Сайнмэдээний гол зүрх юм гэдгийг үргэлж тайлбарласан байдаг. Энэ тухай бид Ром 6:6, 1 Коринт 1:17-18, Галат 6:14, Колоссай 1:20 зэрэг эшлэлүүдээс харж болно. Галат 2:20-21-д хэлсэн Түүний үгийг жишээ болгон сонсоцгооё. Энэ нь:

"Амьд байгаа нь би биш, харин миний дотор амьдардаг Христ юм. Эдүгээ махбоддоо миний амьдарч байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө өргөсөн Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч байгаа хэрэг юм. Би Бурханы нигүүлслийг хөнгөн үзэхгүй. Хэрэв зөвт байдал нь хуулиар ирдэг юм бол Христ дэмий үхсэн аж" гэжээ (Галат 2:20-21).

Христийн үхэл бол бидний авралыг гүйцэлдүүлэх гол үйл хэрэг байсан юм. Тийм ч учраас энэ нь түүхийн туршид Сайнмэдээний гол үнэн байсаар ирсэн.

Есүсийг цовдолсны дараа биеийг нь хадан булшинд оршуулсан ба тэнд гурван өдрийн турш амьгүй байв. Есүс бүрэн дүүрэн хүн байсан тул хүн төрөлхтний туулдаг л үхлийг амссан. Үүнийг Элч нарын тунхагт Тэрээр үхэгсдийн орон руу явсан гэж хэлжээ. Ийнхүү Есүсийн бие булшинд байх зуур сүнс нь үхэгсдийн орон руу буусан аж.

Орчин үеийн теологичид "Тэрээр үхэгсдийн орон руу явсан" гэсэн хэллэгийн утга санаан дээр бүрэн санал нэгддэггүй болохыг энд дурдах нь зүйтэй. Энэ өгүүлбэр бол зөвхөн Есүсийг оршуулсан гэсэн утгатай гэж үздэг сүм чуулганууд олон байдаг. Гэвч Элч нарын тунхагт яг ийм санааг илэрхийлэхийг зориогүй нь тодорхой харагддаг. Элч нарын тунхагт Есүсийг оршуулсан ба үхэгсдийн орон руу явсан гэсэн хоёр санааг аль алийг нь дурдсан шүү дээ. Аль ч талаас нь харсан энэ хоёр өгүүлбэр өөр өөр утгатай, түүхэн дараалсан үйл явдлыг илэрхийлдэг. Нэмж хэлэхэд "үхэгсдийн орон" гэдэг үг нь "газар доорх" гэсэн утгыг илэрхийлдэг бол анхны чуулганы Бичвэр болоод зохиолуудад энэ нь ихэвчлэн үхэгсдийн сүнс байдаг газар доорх ертөнцийг хэлдэг. Тиймээс бид ч бас энэ үгийн утгыг анхны чуулганы илэрхийлж байснаар л ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тэд "үхэгсдийн орон" гэж бичиж байх тэр үедээ юу гэж бодож бичсэн бэ гэдгийг л бодох хэрэгтэй юм.

Эдгээр шалтгааны улмаас Элч нарын тунхаг нь Есүсийн сүнс үхлээс амилалт хүртэлх хугацаанд үнэхээр газар доорх ертөнц рүү явсан гэдгийг ойлгуулахыг зорьсон хэмээн дүгнэх нь зүйтэй. Тэгвэл энэхүү үхэгсдийн орны мөн чанар нь чухамдаа ямар байсан бэ?

Эртний нийгэмд орчлон ертөнцийг ихэвчлэн босоо чиглэл бүхий бүтэцтэй гэж дүрсэлдэг байв. Хүн төрөлхтний амьдардаг газар дэлхий үүнийх нь яг голд нь байна. Тэнгэрийн улс буюу Бурханы болон Түүний тэнгэр элч нарын орон нь дээр тэнгэрт байна. Харин газар дэлхийн доод хэсгийг үхэгсдийн бүх сүнснүүд оршдог газар доорх харанхуй ертөнц гэж үздэг байлаа. Еврей Хуучин Гэрээнд үхэгсдийн ертөнцийг шеол гэдэг. Харин Грек хэл дээрх Шинэ Гэрээ болон Хуучин Гэрээний Грек орчуулгуудад үүнийг хадес гэж нэрлэдэг байв.

Хуучин Гэрээнд бол сайн ба хорон муу бүх хүмүүсийн сүнс тэнд эцсийн шүүлтийг хүлээн байдаг хэмээн өгүүлдэг. Харин Шинэ Гэрээнд Лук 10:15 дээр бичсэнчлэн хадес гэдэг үгээр ихэнхдээ хорон муу хүмүүсийн сүнс байдаг газрыг хэлсэн байдаг. Юутай ч Шинэ Гэрээ ч мөн Есүсийн амиллаас өмнө зөвт хүмүүсийн сүнс *хадест* байсан гэдгийг баталж байна.

Гэхдээ энэ нь хадес буюу үхэгсдийн орон дахь хүн бүр адилхан гэсэн үг биш юм. Лук 16:19-31 дээр буй Лазар ба баян эр хоёрын талаарх Есүсийн ярьсан сургаалт зүйрлэлээс харахад зөвт ба хорон муу хүмүүсийн сүнс том ангалаар тусгаарлагдсан байдаг гэжээ. Хорон муу сүнснүүд тарчилж байхад, зөвт хүмүүсийн сүнс тайтгарч байв. Энэ сургаалт зүйрлэлд Абрахамын сүнс тэрхүү тайвшрал тайтгарлын газар байгаагаар гардаг. Үүнд үндэслэн теологичид хадесын энэ хэсгийг "Абрахамын цээж" буюу шууд утгаараа "Абрахамын өвөр" гэж нэрлэдэг.

Гуравдугаар зууны эхэн үед сүмийн эцэг Тертуллиан хадес доторх хуваагдлын талаарх итгэл үнэмшлээ илэрхийлсэн байдаг. Тэрээр махбодын амиллын тухай бичсэн номынхоо 17-р бүлэгт энэ тухай өгүүлэхдээ:

"Сүнснүүд одоо ч гэсэн Хадест тарчлал болон тайвшралыг амссаар байгааг... Лазарын түүх баталдаг" гэжээ.

МЭ 107 онд сүмийн эцэг Игнатиус Траллианчуудад бичсэн захидалдаа ийнхүү хэлжээ:

"Газар доорх тэдгээр хүмүүсээс үй олон нь Эзэнтэй хамт амилсан. Библид бичсэнээр "нойрссон олон ариун хүний биес амилж", тэдний булш нээгдсэн гэдэг. Есүс үнэхээр Хадес уруу ганцаараа буусан боловч олон хүнтэй хамт амилсан бөгөөд ертөнцийн эхлэлээс оршин байсан тусгаарлалтыг сэтэлсэн юм" гэжээ.

Тиймээс Элч нарын тунхагт Есүсийг үхэгсдийн орон руу явсан гэж хэлснийг Түүний хүмүүн сүнс тэдгээр үхэгсдийн сүнснүүдийн байдаг газарт очсон гэж ойлгох нь хамгийн зөв юм. Ялангуяа хорон муу хүмүүсийн сүнс тарчилж байгаа биш, харин зөвт хүмүүсийн сүнс оршдог газар руу нь явсан гэж хэлж болно. Есүс үхэгсдийн орны энэ хэсэгт очсон нь Түүний үйл хэргийн чухал хэсэг байв. Учир нь энэ нь Түүний сүнсийг жинхэнэ хүмүүний үхлийн шүүлтийн шийтгэлд авчирсан байдаг.

Есүсийн зовлон шаналлаас бид гэм нүгэлд унасан энэ ертөнцөд амьдрах нь чухам ямар байдгийг олж хардаг. Бидний төгс Эзэн гэм нүглийг эсэргүүцэж, засаж залруулахын тулд зовж шаналах ёстой байсан юм бол төгс бус бид ч мөн зовох нь гарцаагүй юм. Үнэндээ 2 Тимот 3:12 дээр Паулын бичсэнчлэн бурханлаг амьдралыг эрэлхийлэгч хүн бүр зовох нь зайлшгүй. Гэвч биднийг зовоход, Христ ч мөн зовдог хэмээн Бичвэрт заадаг. Энэ нь Тэрээр бидний өвчин зовлонг өрөвдөн энэрч, тайтгаруулахыг хүсдэг гэсэн үг юм. Колоссай 1:24 дээр Эцэст нь биднээр дамжин зовж буй Христийн зовлон бүрэн төгсөх болно. Цаг нь болоход Тэрээр сүр жавхлантайгаар эргэн ирж, бид мөнхийн өвийг хүлээн авна. Бидний зовлон утга учиргүй биш ээ. Энэ бол бүх бүтээлд бүрэн сэргэлтийг авчирдаг Бурханы арга хэрэгсэл юм.

Ингээд Есүсийн дорд болсон үйл хэргийн тухай бүгдээрээ үзлээ. Одоо харин Түүний тэнгэрлэг алдар дахин нэг удаа илчлэгдэх үед өргөмжлөгдсөн үйл хэргийн талаар судалцгаая.

Өргөмжлөгдсөн нь

Христийн өргөмжлөгдсөн тухай ярихдаа энэ бол зөвхөн Түүний далдлагдсан алдар сууг ил болгох тухай биш юм гэдгийг санах хэрэгтэй. Дорд болсон үйл хэргээрээ дамжуулан Хүү анх байснаасаа ч илүү агуу алдар сууг хүлээн авсан. Тэрээр Эцэгийнхээ ерөөсөн үйл хэргийг гүйцэлдүүлж, гаргасан золиосоороо хүмүүсийг Өөрийнхөө өв болгон худалдан авсан төдийгүй Бурханы хаанчлалын хаан сэнтийд залрах эрхтэй болсон билээ. Дорд болсон үйл хэргийнхээ үр дүнд Хүүгийн ач гавьяа, магтаал хүндлэл, алдар суу нь үлэмж өссөн.

Христийн өргөмжлөлийн тухай Элч нарын тунхагт дараах зүйлсийг тусгасан байдаг. Энэ нь:

**"Гурав дахь өдрөө үхлээс дахин амилсан,
Тэгээд мөнхийн улс руу одож,
Төгс хүчит Бурхан Эцэгийнхээ Баруун мутарт заларсан,
Тэндээс үхсэн, амьд Бүх хүнийг шүүхээр ирэх" гэжээ.**

Христийн бурханлаг мөн чанар нь үргэлжид өөрчлөгдөлгүй өргөмжлөгдсөн байсан. Түүний энэ чанар хэзээ ч үхэлд захирагдаж, эсвэл тэнгэр дэх хаан сэнтийнээсээ устаж алга болоогүй юм. Тиймээс Бурханы Хүүгийн өргөмжлөл нь хүмүүн мөн чанараар нь хязгаарлагддаг. Гэсэн хэдий ч Христийн хүмүүн мөн чанараараа туулсан бусад бүх зүйлсийнх нь нэгэн адил Түүний бурханлаг бодгаль ч өргөмжлөлийг бүрэн амсаж мэдэрсэн гэсэн үг юм.

Христийн өргөмжлөлийн тухай бид дөрвөн хэсэгт хуваан үзэх болно. Нэгдүгээрт, бид Христ үхлээс амилсан тухай ярилцана. Хоёрдугаарт, Түүний тэнгэр өөд одсон тухай авч үзнэ. Гуравдугаарт, Тэрээр Эцэгийн баруун мутарт залран буй гэдэг нь ямар утгатай болохыг судална. Дөрөвдүгээрт, Түүний ирээдүйд гүйцэтгэх шүүлтийн тухай үзэх болно. Ингээд эхлээд Христ цовдлогдсоноосоо хойш гурван хоногийн дараа үхлээс амилсан тухай ярилцъя.

Амилал

Христитгэгчид ихэнхдээ анзаардаггүй ч гэсэн Христийн амилал нь Түүний үхэлтэй адил бидний авралд чухал үүрэгтэй байсан. Бид Есүс Христийн амиллаар аврагдсан гэж 1 Петр 3:21 дээр хэлсэн нь ч ийм учиртай. Бидний аврал бол зүгээр нэг Христ бидний өмнөөс худалдаж аваад, дараа нь бидэнд бэлэг болгон өгсөн зүйл биш хэдий ч бид үүнийг ихэвчлэн ингэж л тайлбарладаг. Харин энэ нь Есүсийн Өөртэй нь нэгдсэнээр бидэнд өгдөг бэлэг юм. Энэ бол Шинэ Гэрээний захидлуудад олонтоо бичигдсэн "Христ дотор" байх гэдэг ойлголтын гол санаа юм.

Бид Түүнтэй нэгдсэн нэгдлээрээ загалмай дээр хамт үхсэн учраас л Түүний үхлээр дамжуулан уучлагдсан билээ. Мөн бид Түүний амиллаар дамжуулан шинэ амьтай болсон тул мөнхийн амийг хүлээн авдаг. Бичвэр энэ талаар Ром 6:3-11, 8:10-11, 2 Коринт 5:14, 13:4, Колоссай 2:11-3:3 зэрэг олон хэсэгт өгүүлдэг. Ром 6:4-5-р эшлэлд Паулын бичсэн үгсийг жишээ болгон харцгаая. Энд:

"Бид үхэл рүү баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас, Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм. Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж Түүний амилалтай нь ч адил байдалд бас холбогдох болно" гэжээ (Ром 6:4-5).

Товчхондоо, Христ үхэгсдээс амилснаараа гүйцэлдүүлсэн зүйл нь бид ч мөн итгэх үедээ шинэ сүнслэг амьтай болно гэдгийг баталдаг. Тэгээд бид мөн ирээдүйд яг түүнийх шиг амилсан, алдаршуулагдсан бие махбодыг хүлээн авна. Энэ утгаараа Есүсийн өргөмжлөл нь бидний өргөмжлөл бөгөөд бидэнд нэр хүнд, алдар суу ба хүндлэлийг авчрах юм.

Есүсийн үхэл Түүнийг нүглийн хүчнээс хол давсан байр сууринд аваачсан. Үхсэн хүнийг сорьж болохгүй шүү дээ. Тэрээр чөтгөрийн хүчнээс давсан байр суурьтай болсон. Гэвч үхлийн хамгийн том хамсаатан болох нүгэл нь Есүсийг үхэлд хүргэсэн. Тэгээд Есүст үхэлтэй нүүр тулахыг зөвшөөрч, ийнхүү нүүр тулахдаа Есүс үхлийг ялсан билээ. Энэ бүхэн нь Түүний хүмүүст агуу их нөлөө үзүүлсэн. Тиймээс Илчлэл

1:18 дээр Есүс буюу үхлээс амилсан, яруу алдарт Христ Тэрээр, "Би амьд Нэгэн мөн. Би үхсэн. Гэвч харагтун! Би үеийн үед амьд бөгөөд Надад үхлийн ба Үхэгсдийн орны түлхүүр бий хэмээн тунхагласан. Тэрээр энэхүү түлхүүрээр Өөрийгөө чөлөөлсөн бөгөөд Өөртөө хадгалсаар буй. Учир нь нэг л өдөр Тэрээр Өөрийн хүмүүсийг үхлийн хүлээснээс чөлөөлөхийн тулд үүнийг ашиглах болно.

-Др. Нокс Чамбли

Есүсийн загалмай ба амиллаар бид зөвхөн нүглийн уучлалыг буюу нүглийн эвлэрүүллийг хүлээн аваагүй. Харин Есүсийн амилал нь магадгүй бүр илүү чухал зүйл болох ертөнц дэлхийн шинэ бөгөөд эцсийн үеийг эхлүүлсэн явдал юм. Библид хэлсэнчлэн шинэ бүтээлийн үе нь булшнаас, тэрхүү хоосон булшнаас л эхэлсэн байдаг. Энэ бол ертөнцийн шинэ төв/ шинэ цэг, түүхийн шинэ нугалаа юм. Есүс Христ үхлээс амилсан тул бид одоо бүгд эцсийн цаг үед амьдарч байна. Тэрээр энэ төгсгөлийн цаг үеийн эхлэлийг тавьсан. Христитгэгчдийн найдвар бол Христ хоёр дахь удаагаа ирэх үед энэхүү эхлэл үе шувтарч, бүрэн гүйцэт болох явдал юм. Үүнийг Бичвэрт шинэ бүтээл гэж нэрлэдэг.

-Др. Жонатан Т. Пеннингтон

Есүсийн өргөмжлөгдсөн үйл хэрэгт амиллаас гадна газраас тэнгэр өөд одсон нь ч мөн багтдаг.

Тэнгэр өөд одсон нь

Тэнгэр өөд одсон гэдэг нь Есүс бие махбодтойгоо тэнгэр өөд авагдсан гэсэн үг. Үхлээс амилснаасаа дөч хоногийн дараа Есүс үүлэн дунд өргөгдөн, тэнгэр өөд одсон. Лук энэ тухай Лук 24:50-51 болон Үйлс 1:6-11 дээр дурдсан байдаг.

Есүсийн тэнгэр өөд одсон явдал нь Түүний дэлхий дээр байхдаа хийж чадаагүй олон зүйлсийг гүйцэлдүүлсэн. Жишээ нь, Иохан 14:2-3-т Есүс дагалдагч нартаа хандан тэнгэрт тэдэнд орон байр бэлдэхээр явах тухайгаа хэлсэн байдаг. Мөн Иохан 16:7 дээр Тэр Өөрөө эхлээд тэнгэр өөд явахгүйгээр чуулганы үйлчлэлд туслах Ариун Сүнснийг илгээх боломжгүй гэдгийг ч хэлсэн.

Үүнээс гадна Есүс загалмай дээр эхэлсэн гэм нүглийн золилтын ажлаа бүрэн гүйцэлдүүлэхийн тулд тэнгэр өөд одох шаардлагатай байсан юм. Еврей номын бичээч уг номынхоо 8-9-р бүлэгт энэ тухай өгүүлсэн байдаг. Товчхондоо газар дээрх сүм бол тэнгэр дэх сүмийн тусгал юм гэж тэрээр хэлсэн байдаг. Мөн тэрээр Христийн эвлэрүүллийн ажлыг газар дээрх тэргүүн тахилч нарын жил бүр Эвлэрүүллийн Өдөр үйлддэгтэй харьцуулсан байдаг. Энэ өдөр тэд Ариунаас ариун газарт тахилын цусыг авч орон, тахилын ширээн дээгүүр цацаж, тийнхүү хүмүүсийн гэм нүглийн уучлалыг олж авдаг байлаа. Үүнчлэн Есүс тэнгэр дэх жинхэнэ сүмийн Ариунаас ариун газарт орж, Өөрийнхөө цусыг тахилын ширээн дээр цацсан юм. Ийнхүү энэ нь Есүсийн загалмай дээр эхлүүлсэн тахилын ёслолыг бүрэн гүйцэт болгожээ. Еврей 9:11-12 дээр Христийн тэнгэр дэх золилтын ажлыг хэрхэн дүрсэлснийг харцгаая. Энэ нь:

"Харин аль хэдийн...Тэргүүн тахилчаар Христ ирэхдээ илүү агуу бөгөөд илүү төгс асраар нэвтрэв. Энэ асар гараар хийгдээгүй, өөрөөр хэлбэл бүтээлийнх биш ажээ. Тэр... харин мөнхийн золилтыг агуулан, Өөрийнхөө цусаар ариун газарт нэгмөсөн бүгдийн төлөө орсон" гэжээ (Еврей 9:11-12).

Үүнээс гадна, тэнгэр дэх бидний тэргүүн тахилчийн хувьд Христ одоо ч бидний төлөө зуучлан залбирч, биднийг гэм нүгэл үйлдэхэд бидний өмнөөс Өөрийн эвлэрүүллийн ажлын ач тусыг гуйн хүссээр байдаг юм. Теологичид ихэвчлэн Христийн тэнгэр дэх сүмд хийж буй ажлыг нь Бурханы баруун мутарт залран сууж буйгаар нь тодорхойлдог. Чухамхүү энэхүү залрал нь бидний авралыг найдвартай болгодог. Энэ тухай Еврей 7:24-25-р эшлэлд ийнхүү өгүүлжээ:

"Тэр мөнхөд байдаг тул үл өөрчлөгдөх тахилчийн үүрэгтэй. Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрмөсөн аварч чадна. Тэр тэдний төлөө зуучлан залбирч, үргэлж амьд оршдог" гэжээ (Еврей 7:24-25).

Ийнхүү Есүсийн тэнгэр өөд одсон явдал нь Түүний золилтын ажлын чухал хэсэг байсан нь харагдаж байна. Үүнгүйгээр бид аврагдах боломжгүй байсан.

Ингээд бүгдээрээ Христийн амилал ба тэнгэр өөд одсон тухай үзсэн учраас одоо Христ Бурханы баруун мутарт заларсан тухай үзэхэд бэлэн боллоо.

Хаан сэнтийд заларсан нь

Шинэ Гэрээнд Есүс Бурхан Эцгийнхээ баруун мутарт заларсан тухай маш олон удаа дурдсан байдаг. Энэ нь Есүс бол бидний агуу хүмүүн хаан бөгөөд тэнгэрт Эцгийнхээ хаан сэнтийн баруун мутарт залран байдаг гэсэн гол санааг агуулдаг. Энэ тохиолдолд Эцэг бол эрхэм дээд хаан буюу эзэн хаан, харин Хүү бол Түүний доорх харьяат хаан гэсэн үг. Энэ нь харьяат хаад нь эзэнт гүрний тодорхой хэсгүүдийг захирч, эзэн хаанд алба татвар төлж, үйлчилдэг байсан эртний хаанчлалуудын загвартай ижил юм.

Бид Христийн хаанчлалын тухай бодохдоо Тэрээр Бурхан Эцгийнхээ баруун мутарт залран буй Хаан учраас тэртээх өндөрт өргөмжлөгдсөн байгаагаар л ихэвчлэн төсөөлдөг. Гэвч бид Есүс хүмүүн чанарынхаа хувьд хаан ширээнд өргөмжлөгдсөн гэдгийг мартаж болохгүй. Харин Тэрээр Бурхан чанарынхаа хувьд үргэлж хаан байсаар ирсэн. Тэрээр ямагт бүхний дээгүүр бүрэн эрхээрээ захирсаар байсан. Харин Есүсийн хүмүүн чанарт тэнгэр ба газар дээрх эрх мэдэл өгөгдсөн. Мөн Есүс бол Давидын удам учраас Израиль үндэстнийг хийгээд Бурханы ард түмнийг төлөөлдөг. Давид хааны нэгэн адил Давидын Хүү нь харьяат хаан болсон. Өөрөөр хэлбэл Тэрээр тэнгэр дэх Бурхан Эцэг болох агуу их эзэн хааныхаа үйлчлэгч нь байсан гэсэн үг юм.

-Др. Ричард Л. Прат, Жр.

Есүсийг хаан хэмээн дурдсан хэсгүүдэд Түүнийг мөн ард түмнийхээ төлөө зуучлагч тэргүүн тахилч болохыг өгүүлдэг. Энэ нь эртний нийгэмд хаан нь өөрөө тахилчийн үүргийг

гүйцэтгэдэг байсан загварын дагуу байдаг. Жишээ нь, Эхлэл номын 14-р бүлэг дээрх Мелхизедек нь хаан төдийгүй тахилч байсан тухай гардаг.

Бичвэрт Есүсийг Эцэгийнхээ баруун мутарт залран байгааг дурдахдаа заримдаа Тэр бол бидний ирэх Мессиа Хаан гэдгийг Үйлс 2:30-36, Ефес 1:18-23, Еврей 1:3-9, 1 Петр 3:21-22 зэрэг эшлэлүүдэд онцолсон байдаг. Гэхдээ зарим үед Есүсийн бидний төлөө зуучлагч Тэргүүн Тахилчийнх нь үүргийг онцлон тэмдэглэдэг. Бид үүнийг Ром 8:34, Еврей 8:1 зэрэг эшлэлээс харж болно.

Гэвч үнэндээ аль ч тохиолдолд нэг л ижил утгатай байх бөгөөд энэ нь Есүс Эцэгээ төлөөлөн бүхнийг захирдаг ба бүх бүтээлийн дээгүүрх эрх мэдэл, хүч чадалтай гэсэн үг юм. Ийм байр суурьтай учраас л Есүс Өөрийн хүмүүст авралыг авчирч, тэднийг Бурхан Эцэг таалан хардаг болохыг баталдаг.

Элч нарын тунхагт Есүс үхлээс амилан, тэнгэр өөд одож, Эцэгийнхээ баруун мутарт заларсан тухай дурдаад, дараа нь Түүний эцсийн өдөр гүйцэлдүүлэх тэрхүү шүүлтийн тухай өгүүлдэг.

Шүүлт

Тунхагт Есүсийг бүхнийг шүүхээр эргэн ирнэ гэж хэлэхдээ үнэндээ Эцэгийнхээ баруун мутар дахь хаан сэнтийнээсээ ирнэ гэсэн байдаг. Энэ нь Есүс бол бүх бүтээлийн дээрх хүмүүн хаан бөгөөд Өөрийнх нь хуулийг зөрчиж, хаанчлал, хаант улсыг нь хүндлээгүй бүгдийн эсрэг Тэрээр тэнгэрлэг шүүлтийг гүйцэлдүүлэх болно гэсэн санаа юм. Лук 22:30, Үйлс 17:31, 2 Тессалоник 1:5, мөн 2 Тимот 4:1 зэрэг эшлэлүүдээс бид энэ тухай харж болно.

Энэхүү эцсийн шүүлтэд амьд ба үхсэн бүгдийг буюу урьд амьдарч байсан хийгээд Есүсийг эргэн ирэхэд амьд байх бүх хүмүүс орох болно. Бүх хүний үг, үйлдэл, бодол бүр нь Бурханы зан чанарын үндсэн дээр шүүгдэх болно. Хамгийн аймшигт үнэн бол хүн бүр гэм буруутай байх ба үхлийн ялаар буруутгагдах явдал билээ.

Харин бидэнд буй Сайнмэдээ нь итгэлээрээ Христтэй нэгдсэн бүхэн Христийн үхлээр дамжуулан тэрхүү шүүлтийг хэдийнээ давсан байх бөгөөд Христийн амиллаар дамжуулан цагаатгагдах болно гэдэг нь юм. Тиймээс бид шүүлтийн өдөр мөнхийн ерөөл ба өвийг хүлээн авна.

Харин муу мэдээ нь Христ дотор олдоогүй тэдгээр хүмүүс өөрсдийн биеэр Бурханы уур хилэнгийн хатуу ширүүнийг үүрэх болно. Тэд тамд үүрд мөнх хаягдах болно.

Өнөөгийн бидний цаг үед эцсийн шүүлт гэдэг ойлголт биднээс их хол болжээ. Гэхдээ бүх зүйл тийм ч их өөрчлөгдөөгүй гэж би бодож байна. Учир нь шүүлт гэдэг бол анхнаасаа л хүн төрөлхтөнд тийм ч сайхан зүйл байгаагүй. Хэдий тийм ч шүүлтийн тухай тунхаглах нь туйлын чухал гэж би үзнэ. Христэд итгээгүй бүх хүн мөнхийн тамд орно гэдгийг тунхаглах ёстой юм.

-Др. Томас Р. Шрайнэр

Тамын тухай ярих ёстой нэг шалтгаан бол энэ нь маргаангүй үнэн гэдэг нь юм. Бид үнэнээс зугтаж чадахгүй шүү дээ. Хагас үнэн эсвэл бүр ерэн

хувийн үнэн зүйлс олон байдаг. Гэвч бид Сайнмэдээг түгээе гэвэл, үнэнийг түгээе гэвэл эцсийн шүүлтийн тухай ярихаас өөр аргагүй юм. Тийм ч учраас бид тамын тухай ярьдаг бөгөөд ярих ч ёстой. Тамын талаар ярих үед энэ нь бидэнд хэн шүүгч вэ гэдгийг сануулж байдаг. Бид биш, харин Тэр бол шүүгч юм. Энэ нь бидэнд үүрэг хариуцлагыг маань сануулдаг. Мөн энэ нь үнэхээр яаралтай ажил гэдгийг ойлгуулдаг. Мөн бидэнд мөнхийн зүйлсийг сануулдаг. Там олон зүйлстэй салшгүй холбоотой учраас бид Сайнмэдээг тараахдаа тамыг орхих боломжгүй. Тиймээс л бид тамын тухай ярьдаг. Гэхдээ энэ бол үнэн бөгөөд энэхүү үнэнээс зугтахыг хүсэхгүй байгаа учраас бид энэ тухай ярьж байгаа гэдгээ бүү мартаарай.

-Др. Матт Фрайдман

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээрээ бид Элч нарын тунхаг дахь Эзэн Есүс Христийн талаарх итгэлийн үндсэн тунхаглалуудыг судалж мэдлээ. Бид Түүнийг бүрэн дүүрэн Бурхан юм гэдгийг судлахдаа Түүний Бурхан чанар болон Гурвалын бусад бодгалиудтай харилцах харилцааных нь талаар авч үзсэн. Мөн бид Түүнийг бүрэн дүүрэн хүн байсан тухай үзсэн. Ингэхдээ Түүний Бурхан ба хүмүүн чанарын хоорондын харилцааг судалсан. Түүний үйл хэргийг дорд болсон үйл хэргээс нь эхлэн өндөрт өргөмжлөгдсөн үйл хэрэг хүртэл нь нэгтгэн харсан билээ.

Өөрсдийгөө Христитгэгч гэж боддог бүхэн, Христитгэлийг ойлгож судлахыг хүсдэг хүн бүр Христийн бодгаль болон үйл хэргийн тухай сайтар ойлгох нь нэн чухал юм. Есүс бол бидний итгэл үнэмшлийн төв бөгөөд биднийг бусад бүхий л шашны тогтолцооноос ялгаж өгдөг Нэгэн юм. Тэр бол орчлон ертөнцийг захирагч, эргэх бүх түүхийн тулах цэг юм. Тэр бол бидний Бурхан, тэргүүн тахилч, хаан билээ. Түүнийг таньж мэдэж, хайрлаж, Түүнтэй нэгдмэл амьдралтай болох нь бидний аврал мөн.

ХАМТРАГЧИД

Др. Ван Гэйтон (хөтлөгч) бол Виллиамс Библийн Институтийн салбарын захирал, дэрхий даяарх өөр олон сургалт болон их сургуулиудад Библийн багш, илтгэгч. Др.Гэйтон нь мөн Холбооны Шоронгийн товчооны эрхлэгчээр 4 жил үйлчилсэн. Мөн Вашингтоны Шашин ба Олон нийтийн бодлогын институтийн захирлуудын зөвлөлд байсан. Др.Гэйтон нь Олон улсын Семинар сургуулийн Теологийн мастер, Логос Библийн Коллежоос Шашны мастер, Христитгэлийн Удирдлагын Их Сургуулийн Библийн философийн доктор, Фэйт теологийн семинарийн Теологийн доктор, Реформэд теологийн семинарын Үйлчлэлийн доктор зэргийг тус тус хамгаалжээ. Мөн тэрээр Апостолик Саксэшинд бишопоор томилогдож байсан. Христийн Биеийн түүхэн нэгдлийг сэргээх зорилготой Христитгэлийн чуулгануудын Олон улсын Коммунитигийн тэргүүн бишопоор үйлчилж байсан.

Dr. Knox Chamblin (1935-2012) served as Professor of New Testament at Reformed Theological Seminary.

Dr. Paul Chang is the Senior Pastor of Monmouth Chinese Christian Church in Middletown, New Jersey.

Dr. J. Ligon Duncan III is Chancellor and CEO of Reformed Theological Seminary and the John E. Richards Professor of Systematic and Historical Theology.

Dr. Matt Friedeman is Professor of Evangelism and Discipleship at Wesley Biblical Seminary.

Dr. Dennis E. Johnson is Professor Emeritus of Practical Theology at Westminster Seminary California.

Dr. Keith Johnson serves as the National Director of Theological Education for Cru (formerly Campus Crusade for Christ) and is a guest professor of Systematic Theology at Reformed Theological Seminary.

Dr. Robert G. Lister is Associate Professor of Biblical and Theological Studies at the Talbot School of Theology.

Dr. R. Albert Mohler, Jr. is President of The Southern Baptist Theological Seminary.

Dr. J. I. Packer (1926-2020) was Board of Governors' Professor of Theology at Regent College in Vancouver, British Columbia and preached and lectured widely in Great Britain and America.

Dr. Jonathan T. Pennington is Associate Professor of New Testament Interpretation and the Director of Research Doctoral Studies at The Southern Baptist Theological Seminary.

Dr. Richard L. Pratt, Jr. is Co-Founder and President of Third Millennium Ministries.

Dr. Thomas R. Schreiner is the James Buchanan Harrison Professor of New Testament Interpretation and Associate Dean of Scripture and Interpretation at The Southern Baptist Theological Seminary.

Dr. Mark L. Strauss is Professor of New Testament at Bethel Seminary, San Diego.

Dr. K. Erik Thoennes is Professor of Biblical and Theological Studies at Biola University's Talbot School of Theology and is Chair of the Biblical and Theological Studies Theology Department.

Dr. Derek Thomas is Professor of Systematic and Historical Theology at Reformed Theological Seminary in Atlanta, Georgia.

Dr. Peter Walker has served as Professor of Biblical Studies at Trinity School for Ministry and as Associate Vice-Principal at Wycliffe Hall, Oxford. He is currently an instructor with Jerusalem Center for Biblical Studies.

ҮГСИЙН ТАЙЛБАР

Калседон- МЭ 451 онд Христитгэлийн уламжлалт онол сургаалыг хамгаалж, гаж буруу үзлийг няцаах зорилгоор сүмийн зөвлөл хуралдаж байсан бага азийн нэгэн хот.

Калседоны тунхаг- МЭ 451 онд Калседон хотод болсон сүмийн зөвлөлөөс гаргасан тунхаг юм. Энэ нь Есүс бол “жинхэнэ Бурхан, жинхэнэ хүн” гэдгийг онцлон баталсан бөгөөд үүнийг мөн *Калседоны бэлэг тэмдэг* мөн *Калседоны тодорхойлолт* гэж нэрлэдэг.

Христос- Христ гэдэг Грек үг (галиглал) бөгөөд Септуагинтэд “тослогдсон нэгэн” буюу “мешиах” эсвэл “машиах” гэдгийг ийнхүү орчуулсан байдаг.

Хадес- Хорон муу сүнснүүдийн орших газар, мөн зарим тохиолдолд зөвт ба хорон муугийн аль алиных нь байдаг газрыг илэрхийлэхдээ ашигладаг Шинэ Гэрээний Грек нэр томьёо.

Хипостасис- “Үндсэн мөн чанар, шинж чанар” гэсэн утгатай Грек нэр томьёо. Энэ нь Христээс хойших анхны зуунуудад нэг “бодгаль” дотор нэгдмэлээр оршин буй Христийн бурхан ба хүмүүн чанарыг илэрхийлэхдээ ашигладаг байсан үг.

Хипостатик нэгдэл- Христийн бурхан ба хүмүүн чанар нь нэг “бодгаль” дотор нэгдмэлээр оршиж буйг илэрхийлэхдээ ашигладаг хэллэг.

Игнатиус- (ойр. МЭ 50-108 он) Сүмийн Эцэг, Антиохын гурав дахь Бишоп. Тэрээр анхны чуулгануудад теологийн чухал сэдвүүдээр олон цуврал захидлуудыг бичсэн нэгэн.

Биежилт- Есүс хүмүүн чанарыг Өөртөө хүлээн авсан явдлыг тодорхойлдог нэр томьёо.

куриос- “эзэн”, “захирагч”, “ноён” гэсэн утгатай грек үг (галиглал). Энэ нь Шинэ Гэрээн дэх Бурханы нэр юм.

Машиах/мешиах- тослогдсон нэгэн буюу “мессиа” гэсэн утгатай Еврей үг (галиглал).

Зовлон шаналал- “pascho” буюу “зовох” гэсэн Грек үгнээс гаралтай үг (галиглал). Энэ нь Есүсийн баривчлагдсан шөнөөс эхлэн амссан зовлон ба үхлийг илэрхийлдэг.

Септуагинт- Хуучин Гэрээний Грек орчуулга

Залрал- Бурхан Эцэгийнхээ баруун мутарт залран зуучилж буй Есүсийн үүрэг ба үйлчлэлийг илэрхийлдэг теологийн нэр томьёо.

Шеол/sheol - Нас барсан зөвт ба хорон муу хүмүүсийн аль алиных нь сүнс очдог газрыг хэлдэг Хуучин Гэрээн дэх Еврей нэр томьёо (галиглал) .

Сүнс- хүмүүний оршихуйн бодит бус, мөхөшгүй хэсэг буюу бидний бүхий л дотоод, биет бус талыг хэлдэг.

Тертуллиан- (ойр. 155-230 он) анхны чуулганы бичээч, Картежийн сүмийн эцэг. Тэрээр *Маршионыг Няцаах нь* гэдэг номыг бичиж, Гурвалын талаарх хэлэлцүүлгийн Латин нэр томьёог дэлгэрүүлсэн нэгэн.

Гурвал- Бурхан бол гурван бодгалиар оршигч ганц Бурхан гэдгийг илэрхийлдэг теологийн нэр томьёо.